



Европын Холбоо
санхүүжүүлэв



Food and Agriculture
Organization of the
United Nations

НУБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ
“МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТОЙ УЯЛДСАН ТӨСВИЙН
ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГА, ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ



2023 ОН

ННА-65.052
ДАА-657
Х-557

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГА, ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ

Тайлан боловсруулсан:

Л.Мөнхзул, Багийн ахлагч
Д.Нямсүрэн, Зөвлөх
Б.Бүжинлхам, Зөвлөх
Г.Амаржаргал, Зөвлөх

Хянан тохиолдуулсан:

Т.Батсүх, Сангийн яамны төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах зөвлөх

Энэхүү “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн агуулга, үр дүнгийн үнэлгээ” судалгааны тайланг Европын Холбооны санхүүжилттэй “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд боловсруулав. Төслийг Европын Холбооны санхүүжилтээр Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ), НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллага хамтран хэрэгжүүлдэг.

НҮБХХ нь ядуурал, тэгш бус байдал болон уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй шударга бус байдлыг эцэслэх зорилго бүхий НҮБ-ын тэргүүлэх байгууллага юм. Дэлхийн 170 орны түншлэгчид болон мэргэжилтнүүдийн өргөн цар хүрээт хамтын ажиллагааны дүнд эх дэлхий, хүн бүрийн сайн сайхны төлөө хөгжлийн урт хугацааны, цогц шийдлийг бий болгоход улс үндэстнүүдийг дэмжин ажилладаг.

Европын Холбоо бол Европ тивийн 27 тусгаар улсын эдийн засаг, улс төрийн нэгдэл юм. Тус Холбоо нь хүний эрхэм чанар, эрх чөлөө, ардчилал, эрх тэгш байдал, хууль дээдлэх ёс, хүний эрхийг түүний дотор цөөнхийн эрхийг дээдлэх үндсэн үнэт зүйлс дээр тулгуурлан байгуулагджээ. Өнөө цагт Европын Холбоо нь даян дэлхийн хүн бүрд хүртээмжтэй, нийгэм, эдийн засаг, байгаль орчны тогтвортой хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаа явуулж байна.

Ерөнхий мэдэгдэл

Тус тайлан нь Европын Холбоо (ЕХ)-ны санхүүжилтээр хэвлэгдсэн болно. Тайлангийн агуулга зөвхөн зохиогчдын үзэл бодлыг илэрхийлж байгаа бөгөөд ЕХ болон НҮБХХ-ийн албан ёсны бодлого, байр суурийг илэрхийлээгүй. Энэхүү тайланд ашигласан мэдээллийн үнэн зөв эсэх, тухайн материалыг ашигласны улмаас гарах үр дагаварт ЕХ, НҮБХХ хариуцлага хүлээхгүй болно. НҮБХХ-ийн зөвшөөрөлгүйгээр энэхүү хэвлэлийг худалдах, дахин хэвлэх, эсвэл ямар нэгэн ашиг олох хэрэгсэл болгохыг хориглоно.

ISBN: 978-9919-9938-6-3

“Би Си Ай” ХХК-д эхийг бэлтгэж хэвлэв.

АГУУЛГА

ЗУРГИЙН ЖАГСААЛТ.	2
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ.	3
ТОВЧИЛСОН ҮГ	4
1. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРТ ҮНЭЛГЭЭ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ	5
1.1. ХЭД хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх зорилго.	5
1.2. ХЭД хөтөлбөрийн үнэлгээний арга зүй	5
1.3. ХЭД хөтөлбөрт үнэлгээ хийх үндэслэл	6
2. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙН ТУХАЙ	7
2.1. Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаа.	7
2.2. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ	8
2.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	12
3. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙН ҮНЭЛГЭЭ	20
3.1. ХЭД хөтөлбөрийн ач холбогдол	21
3.2. ХЭД хөтөлбөр, арга хэмжээний үр дүн	26
3.2.1. ХЭД үндсэн хөтөлбөр ба арга хэмжээнүүд	30
3.3. ХЭД хөтөлбөр, үйлчилгээний санхүүжилтийн үр ашиг	43
3.4. ХЭД хөтөлбөрийн төлөвлөлт ба гүйцэтгэл.	44
3.5. ХЭД хөтөлбөрийн ерөнхий үнэлгээ	47
4. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ҮНЭЛГЭЭ . . .	48
5. ДҮГНЭЛТ, САНАЛ	53
6. АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ.	56
ХАВСРАЛТ 1: Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих хөтөлбөрийн төрлүүд.	57
ХАВСРАЛТ 2: АСУУЛГЫН АНКЕТ 1.	58
ХАВСРАЛТ 3: АСУУЛГЫН АНКЕТ 2	61

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Ажилд зуучлах үйлчилгээ 2017-2021 он	9
Зураг 2. Ажилд зуучлах үйлчилгээ	11
Зураг 3. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний төсвийн зарцуулалт, хувиар	11
Зураг 4. ХЭД хөтөлбөр ба нийтлэг үйлчилгээнд зарцуулсан хөрөнгө, тэрбум төгрөгөөр	12
Зураг 5. ХЭД хөтөлбөр, арга хэмжээ	13
Зураг 6. ХЭД хөтөлбөрийг батлах, хэрэгжүүлэх процесс	14
Зураг 7. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээний тоо, төрөл	15
Зураг 8. ХЭД хөтөлбөрийн бүтэц, агуулга	17
Зураг 9. 2011-2021 оны хүн ам, хөдөлмөрийн статистик үзүүлэлтийн өөрчлөлт /хувиар/	23
Зураг 10. 2011, 2021 оны хүн амын нас, хүйсийн суварга	24
Зураг 11. Хөдөлмөрийн статистикийн үзүүлэлтүүд, 2021 оны 4 дүгээр улиралд	25
Зураг 12. Ажиллах хүчний үзүүлэлт мян.хүн /2011-2021/	25
Зураг 13. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо /мян.хүн/	25
Зураг 14. Ажилгүйдэл, ядуурлын түвшин /2010-2020/	26
Зураг 15. Халамжаас хөдөлмөрт шилжих бодлогыг тусгасан ХЭД хөтөлбөр	28
Зураг 16. Сургалт зохион байгуулах арга хэмжээний хэрэгжилтийн давтамж	30
Зураг 17. Аж ахуй эрхлэлтийн сургалт	31
Зураг 19. Хөдөлмөр эрхлэлтийн сургалт	31
Зураг 18. Мал маллах арга ухааны сургалт	31
Зураг 20. Хөдөлмөрт бэлтгэх сургалт	31
Зураг 21. Иргэн сургалтанд хамрагдах процесс	32
Зураг 22. Сургалт зохион байгуулах арга хэмжээ /хүний тоогоор/	33
Зураг 23. Сургалт зохион байгуулах арга хэмжээний санхүүжилт /мян.төг/	34
Зураг 24. Нийтийг хамарсан ажил /хүний тоогоор	35
Зураг 25. Нийтийг хамарсан ажлын гүйцэтгэл /мян.төг/	35
Зураг 26. 2021 оны санхүүгийн дэмжлэг арга хэмжээ /ХЭД хөтөлбөрөөр/	36
Зураг 27. Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээний гүйцэтгэл /хүний тоогоор/	37
Зураг 28. Санхүүгийн дэмжлэгийн санхүүжилтийн гүйцэтгэл /мян.төг/	37

Зураг 29. Гарааны бизнесийн экосистемийн индекс 2021	39
Зураг 30. Гарааны бизнесийг дэмжих арга хэмжээний гүйцэтгэл /мян.төг/	40
Зураг 31. Ажилд зуучлах үйлчилгээ/ хүний тоогоор/	41
Зураг 32. Ажилд зуучлах үйлчилгээ /мян.төг/	41
Зураг 33. Тухайн арга хэмжээнд хамрагдсан хүний тоо, эзлэх хувиар	42
Зураг 34. ХЭД хөтөлбөрийн арга хэмжээ төсвийн зарцуулалт, хувиар	44
Зураг 35. Хөтөлбөрийн төсвийн зарцуулалт, хувиар	46
Зураг 36. Үйлчилгээ үзүүлдэг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд	48
Зураг 37. ХЭД хөтөлбөрийн үр дүнд төрийн байгууллагын ажилтнуудын өгсөн үнэлгээ	50
Зураг 38. ХЭД хөтөлбөрт хувийн байгууллагуудын өгсөн үнэлгээ	50

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хэрэгжилт	8
Хүснэгт 2. Нийтлэг үйлчилгээ, 2017-2021	9
Хүснэгт 3. Ажилд зуучлах үйлчилгээ /байгууллагаар/	10
Хүснэгт 4. ХЭҮЗ-өөс ХЭД хөтөлбөрийг баталсан огноо	13
Хүснэгт 5. ХЭД хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг тодорхойлсон байдал	18
Хүснэгт 6. ХЭД хөтөлбөрийн хэрэгжилтийн ерөнхий үнэлгээ	20
Хүснэгт 7. 2011, 2021 оны хөдөлмөр эрхлэлтийн статистик үзүүлэлтүүд	22
Хүснэгт 8. Гарааны бизнесийн экосистемийн индекс 2021: Топ 10 улс ба Монгол улс	39
Хүснэгт 9. Залуучуудын гарааны бизнесийг дэмжих арга хэмжээний гүйцэтгэл /хүний тоогоор/	40
Хүснэгт 10. ХЭД хөтөлбөр, үйлчилгээнд зарцуулсан хөрөнгө	43
Хүснэгт 11. ХЭД хөтөлбөрийн төсвийн 2021 оны 10 ба 12 дугаар сарын гүйцэтгэл	45
Хүснэгт 12. ХЭД хөтөлбөрийн үр дүнгийн үнэлгээ	47
Хүснэгт 13. 2021 оны ХЭД хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын үнэлгээ	49

ТОВЧИЛСОН ҮГ

ААН	Аж ахуйн нэгж
АМЧБО	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох
АЗҮ	Ажилд зуучлах үйлчилгээ
ДБ	Дэлхийн банк
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗГ	Засгийн газар
ЕХ	Европын Холбоо
МБС	Мэргэжлийн боловсрол, сургалт
МБСБ	Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага
МУ	Монгол Улс
НҮ	Нийтлэг үйлчилгээ
НҮБХХ	Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөр
НХЭГ	Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
СЯ	Сангийн яам
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ТББ	Төрийн бус байгууллага
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХБХ	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд
ХБХХЕГ	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар
ХНХ	Хөдөлмөр, нийгмийн хамгаалал
ХНХСИ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХТХ	Хөдөлмөрийн тухай хууль
ХХДХ	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ХХҮХ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс
ХЭД	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ХЭҮЗ	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл
ШХА	Швейцарын хөгжлийн агентлаг
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа ба хөгжлийн байгууллага
ЭХМК	Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс

1

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРТ ҮНЭЛГЭЭ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

1.1. ХЭД ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЭХ ЗОРИЛГО

2012-2021 онд хэрэгжүүлсэн ХЭД хөтөлбөрийн зорилго, агуулга, хамрах хүрээ буюу зорилтот бүлэг, хэрэгжүүлсэн арга хэмжээ, удирдлага зохион байгуулалт, санхүүжилт, хөтөлбөрийн хүрэх үр дүн, гүйцэтгэлд тавьсан шалгуур үзүүлэлт, хяналт шинжилгээнд дүн шинжилгээ хийж цаашид хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааны хэрэгжилтийг сайжруулах дүгнэлт, зөвлөмж өгөхөд оршино.

1.2. ХЭД ХӨТӨЛБӨРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

2012-2021 онд хэрэгжүүлсэн ХЭД хөтөлбөрийн үр дүнг үнэлэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримталснаас гадна олон улсад нийтлэг хэрэглэдэг ЭЗХАХБ-ын төслийн үнэлгээний аргачлал, (OECD, DAC¹ Methods and Procedures in Aid Evaluation Dimensions, Relevance, Effectiveness, Efficiency, Impact, Sustainability²) АХБ-ны төслийн үр дүнг үнэлэх аргачлалыг тус тус удирдлага болгов.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл (ХЭҮЗ)-өөс 2012-2021 онд баталсан ХЭД хөтөлбөрүүдийг харьцуулан шинжилж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ), Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар (ХХҮЕГ)-ын мэдээ тайлан, www.1212.mn вэб сайт, болон бусад албан ёсны мэдээллийн эх сурвалж, судалгаа, тайлангийн материалууд, тухайн асуудал хариуцсан удирдах ба гүйцэтгэх албан тушаалтнуудаас тодруулга, мэдээлэл авч энэхүү үнэлгээний тайланг боловсруулав.

1 Development Assistance Committee, Principles for Evaluation of Development Assistance, Paris 1991

2 The DAC Principles for the Evaluation of Development Assistance, OECD (1991), Glossary of Terms Used in Evaluation, in 'Methods and Procedures in Aid Evaluation', OECD (1986), and the Glossary of Evaluation and Results Based Management (RBM) Terms, OECD (2000)

1.3. ХЭД ХӨТӨЛБӨРТ ҮНЭЛГЭЭ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ

ХЭҮЗ нь 2012-2021 оны 10 жилийн хугацаанд нийт 8 удаа ХЭД хөтөлбөр баталжээ. Энэ хугацаанд ХЭД хөтөлбөрүүдэд цогц байдлаар үнэлгээ хийгдээгүй, хөтөлбөрийн хэрэгжилт, гүйцэтгэлийг зөвхөн тоогоор дүгнэж ирсэн, статистик мэдээ үзүүлэлт тодорхой бус зөрүүтэй байдаг, нарийвчилсан мэдээ гардаггүй гэх мэт анхаарч үзэх асуудал их байна. Тиймээс төрөөс хэрэгжүүлж буй хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаа, үр дүнг сайжруулах, хөдөлмөрийн статистик судалгаа хоорондын уялдаа, харилцан хамаарал, хөтөлбөрийн хэрэгжилтэд нөлөөлсөн хүчин зүйлийг тодорхойлох суурь үнэлгээ хийх зайлшгүй шаардлага гарч ирсэн.

Монгол улсад Тогтвортой хөгжлийн зорилгыг хангаж биелүүлэхийн тулд төрөөс хэрэгжүүлдэг хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг илрүүлэх, тэдгээрийг эрэмбэлж, боловсронгуй болгох асуудал чухал шаардлагатай байна. ХЭД хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ хийхдээ баримт бичгийн судалгаа, захиргааны статистик тоо мэдээлэлд хийсэн харьцуулсан дүн шинжилгээ, эрх бүхий албан тушаалтан, мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлага, өмнө хийгдсэн судалгаа, тайлан болон хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаанд оролцогч сургалтын байгууллага, хувийн бирж зэрэг байгууллагаас авсан санал асуулгад үндэслэв.

2

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙН ТУХАЙ

2.1. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монгол Улс нь ОУХБ-ын Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын тухай 1964 оны 122 дугаар конвенцийг 1976 онд соёрхон баталсан. Энэ конвенц нь гишүүн орон бүр бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийг устгах, ажиллах хүчний хэрэгцээг хангах, амьдралын түвшинг дээшлүүлэх, эдийн засгийн хөгжил, түүний өсөлтийг урамшуулах зорилгоор үр ашигтай, бүрэн, чөлөөт хөдөлмөр эрхлэлтийн сонголтод дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн идэвхтэй бодлогыг гол зорилго болгосон.

Энэ конвенцийн үзэл баримтлалын дагуу манай улс социалист нийгмийн үед бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийг устгаж, иргэн бүр эрх тэгш байх суурь зарчмыг ханган ажиллаж байсан.

Монгол Улс 1990 оноос зах зээлийн эдийн засагт шилжсэн бөгөөд 1992 онд Үндсэн хуулиа баталж, мөн онд Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үзэл баримтлалыг Засгийн газрын 1992 оны 106 дугаар тогтоолоор баталсан байдаг.

Хувийн хэвшил үүсэн хөгжиж, зах зээлийн чөлөөт эдийн засгийн тогтолцоонд шилжсэнээр ажилгүйдэл үүсэж, инфляц маш хурдацтай өсөж, орлогогүй иргэд нэмэгдэж ядуурал бий болсон. Бүх нийтийн нийгмийн хамгааллын баталгааг хангах зорилгоор Нийгмийн даатгалын багц хуулийг 1994 онд, Нийгмийн халамжийн багц хуулийг 1995 онд тус тус баталсан. Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулиар ажилгүйдлийн даатгалын санг бий болгож ажилтан, ажил олгогч хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос ижил 0.5 хувиар шимтгэл төлөхөөр тусгасан ба 2022 оны байдлаар 0.2 хувиар ажилгүйдлийн даатгалын шимтгэл төлж байна. 1995 онд ажилгүйдэл ядуурлын улсын үзлэг явуулж, улмаар Хүн амын амьжиргааны түвшин тодорхойлох тухай хуулийг 1998 онд батлан мөрдүүлж байжээ.

Түүнчлэн УИХ-аас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг 2001 онд баталж, 2011 онд шинэчлэн найруулсан бөгөөд хуульд 2012, 2014, 2015, 2016, 2017, 2021 онуудад нэмэлт, өөрчлөлт оруулсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг

- 1) Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ;
- 2) Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ;

гэсэн 2 төрөлтэй байна гэж тодорхойлсон бөгөөд мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т ХЭД арга хэмжээг төсөл хөтөлбөрийн хэлбэрээр хэрэгжүүлнэ гэж заасан байдаг.

2.2. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг дараах хэлбэрээр хэрэгжүүлдэг. Үүнд:

1. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах;
2. Ажилд зуучлах;
3. Ажилгүйдлийн тэтгэмж авах иргэдийг бүртгэх;
4. Нэгдсэн бүртгэл, мэдээллийн үйлчилгээнд хамруулах;
5. Бусад үйлчилгээ.

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг ХХҮЕГ, аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар (ХХҮГ), Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар, дүүргийн ХХҮХ болон эрх бүхий сургалтын байгууллага, хөдөлмөрийн хувийн биржээр дамжуулан хэрэгжүүлж байна.

2021 оны жилийн эцсийн байдлаар ХХҮЕГ-т хөдөлмөрийн 88 хувийн бирж бүртгүүлснээс 32 хөдөлмөрийн бирж нь идэвхтэй үйл ажиллагаа явуулж ХЭДС-аас санхүүжилтээ авчээ.

ХХҮЕГ нь жил бүр сонгон шалгаруулалт зарлаж шаардлага хангасан байгууллагад хөдөлмөрийн хувийн биржийн үйл ажиллагаа явуулах 2 жилийн зөвшөөрөл олгодог бөгөөд жил бүр гэрээний гүйцэтгэлийг дүгнэдэг. Хувийн биржүүд ажилд зуучилсан иргэдийн мэдээллийг сар бүрийн 26-наас өмнө цахим мэдээллийн санд бүртгэж, гүйцэтгэлийн тайлангаа цаасан хэлбэрээр ХХҮЕГ-т өгдөг. ХХҮЕГ-ын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих газрын Ажил мэргэжлийн чиг баримжаа, хөдөлмөрийн биржийн үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн хянан шалгаж, санхүүжилтийг дараа сард нь олгодог байна. ХЭДС-ийн санхүүжилт 3 дугаар сараас эхэлж олгогддог учраас 1 ба 2 дугаар сарын тайланг 3 дугаар сард хүлээж авдаг байна.

ХҮСНЭГТ 1. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хэрэгжилт


	Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ	Зохион байгуулах байгууллага	Хэрэгжүүлэгч буюу санхүүжилт авах байгууллага	Санхүүжилтийн арга
1	Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ	НХЭГ, Аймаг, дүүргийн ХХҮГ/Х	Эрх бүхий сургалтын байгууллага	1 иргэнээр, урьдчилгаа 70%, сургалт дуусаж тайлан өгснөөр гүйцэтгэл 30%
2	Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ	ХХҮЕГ	Хөдөлмөрийн хувийн бирж	Гүйцэтгэлийн тайлангаар 100%
3	Ажилд зуучлах үйлчилгээ	НХЭГ, Аймаг, дүүргийн ХХҮГ/Х	НХЭГ, Аймаг, дүүргийн ХХҮГ/Х	Төсвийн гүйцэтгэлээр
4	Ажилд зуучлах үйлчилгээ	ХХҮЕГ	Хөдөлмөрийн хувийн бирж	Гүйцэтгэлийн тайлангаар 100%

Зарим аймаг, дүүргийн ХХҮГ/Х нь ганцаарчилсан зөвлөгөө өгөх өрөө байхгүй эсхүл үйлчлүүлэх хүний тоо харьцангуй их байдаг учраас нийтлэг үйлчилгээг шаардлагын дагуу хүргэх боломжгүй байдаг. Нийслэлийн хөдөлмөр эрхлэх газар (НХЭГ), аймаг, дүүргийн ХХҮГ/Х-үүд нь иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх төлөвлөгөөнийхөө 20-30%-ийг өөрсдөө, 70-80%-ийг эрх бүхий сургалтын байгууллагуудтай гэрээ байгуулан гүйцэтгүүлдэг.

Аймаг, нийслэлийн ХХҮГ, дүүргийн ХХҮХ иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг үзүүлэхдээ ХНХ-ын Сайдын 2021 оны 6 сарын 18-ны өдрийн А/96 тоот тушаалаар баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний зардлын жишиг хэмжээ”-ээр санхүүжилтээ авдаг. Харин хөдөлмөрийн хувийн биржүүд АМЧБО зөвлөх үйлчилгээг үзүүлэхээр ХХҮЕГ-тай гэрээ байгуулж ажиллаж байгаа бол Хөдөлмөрийн сайдын 2014 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн А/123 тоот тушаалаар баталсан “Хөдөлмөрийн хувийн биржийг бүртгэж санхүүжилт /тарифаар тооцож/ олгох журам”-ын дагуу өөр тарифаар санхүүжилтээ авдаг. Цаашид нийтлэг үйлчилгээний жишиг зардлыг ижил тарифаар, нэг журмаар зохицуулдаг болох нь зүйтэй юм.

Нийтлэг үйлчилгээнд сүүлийн 9 жилийн хугацаанд 1,107,186 иргэнийг хамруулсан. 2017-2021 онд ажлын байранд нийт зуучлагдсан хүний тоо 189,381 байна /Зураг 1/.

ЗУРАГ 1. Ажилд зуучлах үйлчилгээ 2017-2021 он



Эх сурвалж: ХХҮЕГ-ын мэдээлэл

Дээрх зургаас харахад ажлын байрны захиалгын тоо ажил хайгчийн тооноос илүү бүртгэгдсэн байна. Ажил олгогчийн зүгээс ажлын байрны шаардлагад нийцсэн ажил хайгчид багассан, ажил хийх хүн олдохгүй байна гэж үзэж байхад ажил хайгч иргэд цалин хөлс багатай, ажлын нөхцөл хүнд, илүү цагаар ажиллуулдаг, ажлын байршил хол гэх мэт олон шалтаг, шалтгаанаар орох сайн ажил олдохгүй байна гэж үзэх хандлагатай байна.

ХҮСНЭГТ 2. Нийтлэг үйлчилгээ, 2017-2021

Үзүүлэлт		АМЧБО, зөвлөх үйлчилгээ	Ажилд зуучлах үйлчилгээ
2017	Хамрагдсан хүн	103,862	45,683
	Зарцуулсан хөрөнгө /сая.төг/	535.4	273.7
2018	Хамрагдсан хүн	89,961	43,105
	Зарцуулсан хөрөнгө /сая.төг/	646.1	359.2

2019	Хамрагдсан хүн	118,584	44,059
	Зарцуулсан хөрөнгө /сая.төг/	789.2	546.2
2020	Хамрагдсан хүн	51,567	33,006
	Зарцуулсан хөрөнгө /сая.төг/	384.1	288.9
2021	Хамрагдсан хүн	54,401	23,538
	Зарцуулсан хөрөнгө /сая.төг/	557.5	250.9

Эх сурвалж: ХНХЯ, ХХҮЕГ-ын мэдээлэл

2017-2021 оны хооронд нийт 418.4 мянган хүн ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамрагдаж, 2,912.3 сая төгрөг зарцуулсан байна. Мөн 189.4 мянган иргэн ажилд зуучлуулж 1,718.9 сая төгрөг зарцуулсан байна. /Хүснэгт 2/

Нийт зуучлагдсан иргэдийн 90 гаруй хувь нь ХХҮГ/Х-ээр зуучлагддаг. 2021 оны байдлаар ажил зуучлагдсан иргэдийн 7.6% нь хөдөлмөрийн хувийн биржээр зуучлагдсан байна. /Хүснэгт 3/

ХҮСНЭГТ 3. Ажилд зуучлах үйлчилгээ /байгууллагаар/


№	Байгууллага	2020		2021	
		Хүний тоо	Зарцуулсан хөрөнгө (сая төг.)	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгө (сая төг.)
1	НХЭГ, аймаг дүүргийн ХХҮГ/Х	31,364	200.4	23,538	163.3
2	Хөдөлмөрийн хувийн бирж	1,642	92.7	1,787	87.7
3	Нийт	33,006	293.1	25,325	251.0

Эх сурвалж: ХХҮЕГ-ын мэдээлэл

Аймаг, дүүргийн ХХҮГ\Х-үүд хөтөлбөр хэрэгжүүлэхэд илүү анхаарч, ажилд зуучлах үйлчилгээ үзүүлэх цаг зав хомс байдаг. Тийм боловч жил бүр 30 гаруй мянган иргэнийг ажилд зуучилсан үзүүлэлттэй байгаа нь бодит байдалд нийцэхгүй байна. Жишээлбэл, 2020 онд Ковид-19 цар тахлын хөл хориотой үед НХЭГ, аймаг дүүргийн ХХҮГ/Х 31,364 хүнийг ажилд зуучилсан нь 12 сараар, сард ажлын 22 өдрөөр тооцвол өдөрт 140 хүн буюу нэг нэгж 4-5 хүнийг өдөр бүр ажилд зуучилж байсан гэсэн үг юм. Хэрвээ хөл хориотой байсан цаг хугацаа болон санхүүжилт гаргаагүй 1 ба 2 дугаар сарыг хасч тооцвол нэг нэгж 7-8 хүнийг өдөр бүр ажилд зуучилж байсан гэсэн үг юм. Энэ тоо бодитой эсэх нь эргэлзээтэй байна.

Иргэнд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг үзүүлэхдээ эхлээд мэдээллийг нь ХЗЗ-ийн мэдээллийн санд бүртгэж, АМЧБО зөвлөгөө өгч, тохирох ажлын байранд зуучилдаг. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээнд хамрагдсан нийт иргэдийн 37.2%-64% нь ажилд зуучлагддаг гэсэн үзүүлэлттэй байна /Зураг 2/.

ЗУРАГ 2. Ажилд зуучлах үйлчилгээ




Эх сурвалж: ХНХЯ, ХХҮЕГ-ын мэдээлэл

ХЭДС-ийн зардлын хуваарилалтад нийтлэг үйлчилгээний төсөв маш бага хувь эзэлдэг бөгөөд нийтлэг үйлчилгээний зардлын хуваарилалтад ажилд зуучлах үйлчилгээ нь ердөө 31-42.9%-ийг эзэлж байна /Зураг 2/. Энэ нь маш бага хувийг эзэлж байгааг харуулж байна.

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний төлөвлөлтийг авч үзвэл Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох (AMЧБО) үйлчилгээ сүүлийн 6 жилээр 71.2-90.8%-ийн гүйцэтгэлтэй, харин ажилд зуучлах үйлчилгээ 34,2-89,6%-ийн гүйцэтгэлтэй байна /Зураг 3/.

ЗУРАГ 3. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний төсвийн зарцуулалт, хувиар




Эх сурвалж: ХНХЯ, ХХҮЕГ-ын мэдээлэл

Ажилд зуучлах үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо буурч байсан боловч төсвийн зарцуулалтын гүйцэтгэл өсөлттэй гарсан нь жил бүр ажилд зуучлах үйлчилгээний квотыг багасгаж байсантай холбоотой байна.

2012-2021 онд ХЭДС-ийн төсвийн 1.7-5.5%-ийг хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд зарцуулсан байна. Энэ нь ажилгүй иргэдийг ажилтай болгох хамгийн чухал үйлчилгээнд төсөв бага хуваарилдаг болохыг илтгэж байна /Зураг 4/.

ЗУРАГ 4. ХЭД хөтөлбөр ба нийтлэг үйлчилгээнд зарцуулсан хөрөнгө, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: ХНХЯ, ХХҮЕГ-ын мэдээлэл

Сүүлийн 10 жилийн хугацаанд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд нийт 9.2 тэрбум төгрөг зарцуулсан байна. 2013-2021 оны хооронд 9 жилийн дунджаар 1 хүнд 8.3 мянган төгрөг зарцуулсан байна.

2.3. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

2011 онд баталсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг дараах төсөл, хөтөлбөрийн хэлбэрээр хэрэгжүүлнэ” гэж заасан. Үүнд:

1. Хөдөлмөрт бэлтгэх;
2. Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах;
3. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийг дэмжих, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих;
4. Ажил олгогчийг дэмжих;
5. Нийтийг хамарсан ажил зохион байгуулах;
6. Ажил олоход хүндрэлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;
7. Хууль тогтоомжид болон Засгийн газар, ХЭҮЗ-ийн шийдвэрээр тодорхойлсон бусад төсөл, хөтөлбөр.

2012 оноос хойш 10 жилийн хугацаанд ХЭҮЗ-өөс ХЭД хөтөлбөрүүдийг нийт 8 удаа баталжээ. /Хүснэгт 4, Зураг 5/

ХҮСНЭГТ 4. ХЭҮЗ-өөс ХЭД хөтөлбөрийг баталсан огноо

№	Баталсан огноо	Хөтөлбөрийн тоо	Арга хэмжээний тоо	Хэрэгжсэн он	ХЭҮЗ тогтоолын дугаар
1.	2012.03.12	5	22	2012	2
2.	2012.12.12	8	25	2013	4
3.	2014.01.13	10	33	2014	5
4.	2015.02.12	5	18	2015	7
5.	2015.12.16	8	22	2016	8
6.	2017.01.27	6	19	2017-2018	1
7.	2019.01.14	6	27	2019-2020	1
8.	2021.02.09	5	20	2021	1
9.	Нийт	65*	232*		

Эх сурвалж: ХЭҮЗ-ийн тогтоолууд

*2 жилийн хугацаатай батлагдсан ХЭД хөтөлбөр, арга хэмжээг 2-оор үржүүлж тооцов.

ЗУРАГ 5. ХЭД хөтөлбөр, арга хэмжээ




Эх сурвалж: ХЭҮЗ-ийн тогтоолоор батлагдсан ХЭД хөтөлбөрүүд

Дээрхээс харвал 2012, 2015, 2021 онуудад хамгийн бага буюу 5 хөтөлбөр, 2014 онд хамгийн их буюу 10 хөтөлбөр, 33 арга хэмжээг баталж хэрэгжүүлсэн. Төсвийн зарцуулалт, цаглаврыг авч үзвэл ХЭД хөтөлбөрийг ХЭҮЗ-өөр өмнөх оны 11 дүгээр сарын 15-наас 12 дугаар сарын 25-ны дотор баталж, дараа ондоо хэрэгжүүлэх нь хамгийн оновчтой хувилбар юм. Батлагдсан цаглавраас харвал 2013, 2016 онуудад хэрэгжүүлсэн ХЭД хөтөлбөр өмнөх ондоо батлагдаж, 2018, 2020 онуудад өмнөх оны хэрэгжсэн хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн байна. Бусад онуудад хэрэгжсэн хөтөлбөрүүдийг тухайн оныхоо 1-3 дугаар сард баталж санхүүжилт, үйл ажиллагаа нь хойшлогдож, улмаар хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд сөргөөр нөлөөлж байжээ.

ХХҮЕГ нь НХЭГ, аймаг, дүүргийн ХХҮГ/Х-ээс санал авч, нэгтгэн ХЭД хөтөлбөрийн саналаа ХНХЯ-нд хүргүүлдэг. ХНХЯ нь ХЭД хөтөлбөрийн саналыг хүлээн авч ажлын хэсэг томилон эцсийн хувилбарыг боловсруулж ХЭҮЗ-өөр батлуулдаг. Батлагдсан ХЭД хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдамжийн төслийг ХХҮЕГ-аас боловсруулж, ХНХЯ-наас баталсны дараа нийслэл, аймаг дүүргийн ХХҮГ/Х нь хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхэлдэг. /Зураг 6/

ЗУРАГ 6. ХЭД хөтөлбөрийг батлах, хэрэгжүүлэх процесс




Эх сурвалж: ХНХЯ, ХХҮЕГ-ын мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлага

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоолоор ХЭД хөтөлбөрийг, ХНХ-ын сайдын тушаалаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн нэгдсэн төсвийн хуваарийг, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын тушаалаар аймаг, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн төсвийн хуваарийг тус тус баталж байна.

ХЭД хөтөлбөр нь агуулгын хувьд туршилтын, цаг үетэйгээ уялдсан, байнгын, зорилтот бүлэгт чиглэсэн шинжтэй байна. ХЭД хөтөлбөрүүдийн нэр, агуулга, арга хэмжээг авч үзвэл давхцаагүй нэршлээр 28 хөтөлбөр батлагдаж, зардлын задаргаагаар 64 төрлийн арга хэмжээ хэрэгжсэн байна. /Зураг 7, ХЭД хөтөлбөрүүдийн нэрийг Хавсралт 1-ээс харна уу/ Хэдийгээр 64 арга хэмжээ хэрэгжсэн ч багцалж үзвэл үндсэн 5 арга хэмжээ, бусад гэсэн 6 төрөлд хувааж болохоор байна.

ЗУРАГ 7. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээний тоо, төрөл



Эх сурвалж: ХЭҮЗ-ийн тогтоолоор батлагдсан ХЭД хөтөлбөрүүд
Зөвлөх Д.Нямсүрэн 2012-2021 оны хооронд ХЭҮЗ-өөр батлагдаж хэрэгжсэн ХЭД хөтөлбөрүүдэд анализ хийж төрөлжүүлэв.

2012-2021 онд баталж хэрэгжүүлсэн ХЭД хөтөлбөрийг давхцаагүй нэршил, зорилго болон хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдээр нь багцалж 7 хөтөлбөрт хувааж үзэв. Үүнд:

I. Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр

1. Хөдөлмөрт бэлтгэх;
2. Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах;
3. АМЧБО зөвлөх үйлчилгээг дэмжих;
4. Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох;
5. Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, ажлын байр хадгалах;
6. Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, ажлын байрыг дэмжих;
7. Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх;

II. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр

8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;
9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр;

III. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр

10. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;

IV. Ажлын байрыг дэмжих хөтөлбөр

11. Ажил олоход хүндрэлтэй иргэнийг ажлын байраар хангасан ажил олгогчийг дэмжих;
12. Ажил олгогчийг дэмжих;
13. Ажлын байрыг дэмжих;
14. Хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих;
15. Аж ахуй эрхлэлтийг хөгжүүлэх хөтөлбөр;
16. Аж ахуй эрхлэх, бичил бизнесийг дэмжих хөтөлбөр;
17. Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх;

V. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр

18. 40-өөс дээш насны болон ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр;
19. 40-өөс дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр;
20. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ төсөл;
21. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр;
22. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр;

VI. Нийтийг хамарсан ажил зохион байгуулах хөтөлбөр

23. Эзэнтэй монгол хөтөлбөр;
24. Нийтийг хамарсан ажил зохион байгуулах хөтөлбөр;


VII. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр

25. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр;
26. Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр;
27. Оюутны хөдөлмөр эрхлэлт ба цагийн ажил хөтөлбөр;
28. Залуучууд, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр.

ХЭД хөтөлбөрүүд нь агуулгын хувьд тухайн ХЭД хөтөлбөрийн онцлогийг тусгасан нэр, хөтөлбөрийн зорилго, хэрэгжүүлэх арга хэмжээ, хамрах хүрээ буюу зорилтот бүлэг, удирдлага

зохион байгуулалт, санхүүжилт, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн, тайлагнал, хяналт-шинжилгээ, үнэлгээ гэсэн ерөнхий бүтэцтэй байна. /Зураг 8/

ЗУРАГ 8. ХЭД хөтөлбөрийн бүтэц, агуулга



Эх сурвалж: ХЭД хөтөлбөрүүд

ХЭД хөтөлбөрүүдийг агуулгын хувьд авч үзвэл зарим жилүүдэд шалгуур үзүүлэлтийг тодорхойлоогүй, хүрэх үр дүнг тоон үзүүлэлтээр илэрхийлээгүй, хөтөлбөрийн хяналт шинжилгээ үнэлгээг тусгаагүй учраас хөтөлбөрийн үр дүнг үнэлэхэд бэрхшээлтэй байна. Тиймээс цаашид ХЭД хөтөлбөрийн агуулгыг боловсруулахдаа эдгээр асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

ХЭД хөтөлбөрийг үнэлэх зорилгоор ХНХЯ, ХХҮЕГ, ХХҮГХ-ийн ажилтнуудаас анкетын аргаар асуулга боловсруулж онлайнаар судалгаа авсан. Уг судалгаанд 110 албан хаагч оролцож, дараах шалтгаануудаас болоод зарим хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжээгүй гэж үзсэн байна. Үүнд:

- ◆ Хөтөлбөрийн арга хэмжээ оновчгүй - 46.9%
- ◆ Орон нутгийн онцлогт тохироогүй - 44.9%
- ◆ Хэрэгжүүлэх хүний нөөц дутмаг - 39.8%
- ◆ Арга хэмжээнд төсөв хуваарилаагүй - 20.4%
- ◆ Зохион байгуулах газар, хэлтсийг зөв тодорхойлоогүй - 11.2%
- ◆ Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдамж батлагдаагүй - 10.2%
- ◆ Хөтөлбөр удирдамж оройтож ирдэг, Ковид, хөл хорио гэх мэт бусад шалтгаанаас - 9%

хамаарч зарим арга хэмжээ амжилтгүй, гүйцэтгэл дутуу болон огт хэрэгжээгүй гэж үзсэн.

2012 оноос хэрэгжиж ирсэн ХЭД хөтөлбөрт шалгуур үзүүлэлт үр дүнг тодорхойлохдоо тухайн хөтөлбөрт хамруулахаар төсөвт тусгасан оролцогчийн тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээгээр тооцож ирсэн байна. Зарим жилүүдэд ХЭД хөтөлбөрийг боловсруулахдаа шалгуур үзүүлэлтийг орхигдуулсан бөгөөд хүрэх үр дүнгээ тоогоор илэрхийлээгүй байна. /Хүснэгт 5/

Дараах хүснэгтээс харахад ХЭД 28 хөтөлбөрөөс шалгуур үзүүлэлт нь бүрэн тодорхойлогдсон 13 хөтөлбөр, зарим жилүүдэд тодорхойлсон 9 хөтөлбөр, огт тодорхойлоогүй 6 хөтөлбөр байна. ХЭД хөтөлбөрийн хүрэх үр дүнг тоогоор бүрэн илэрхийлсэн 6 хөтөлбөр, зарим жилүүдэд тодорхойлогдсон 3 хөтөлбөр, огт тоогоор илэрхийлээгүй 19 хөтөлбөр байна.

ХҮСНЭГТ 5. ХЭД хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг тодорхойлсон байдал

№	Хөтөлбөрийн нэр	Хэрэгжсэн он	Шалгуур үзүүлэлттэй эсэх	Хүрэх үр дүн хэмжих тоон үзүүлэлттэй эсэх
1	Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр	2012, 2013, 2014, 2021	2013, 2014 онд үгүй	2012, 2013 үгүй, 2014, 2021 тийм,
2	Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах хөтөлбөр	2012, 2013	2013 онд үгүй	тийм
3	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээг дэмжих	2016	тийм	үгүй
4	Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр	2017, 2018, 2019, 2020	тийм	2017, 2018 үгүй, 2019, 2020 тийм
5	Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, ажлын байр хадгалах хөтөлбөр	2015	тийм	үгүй
6	Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, ажлын байрыг дэмжих хөтөлбөр	2016	тийм	үгүй
7	Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх	2014	үгүй	үгүй
8	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	2013, 2021	2013 онд үгүй	2013 үгүй, 2021 тийм
9	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	2014-2020	2014 онд үгүй	үгүй
10	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	2012-2020	2013, 2014 онд үгүй	үгүй
11	Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр	2021	тийм	тийм
12	Ажил олоход хүндрэлтэй иргэнийг ажлын байраар хангасан ажил олгогчийг дэмжих	2012	тийм	үгүй
13	Ажил олгогчийг дэмжих хөтөлбөр	2013	үгүй	үгүй
14	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	2017-2020	тийм	үгүй
15	Хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр	2012, 2013, 2015	2013 онд үгүй	үгүй
16	Аж ахуй эрхлэлтийг хөгжүүлэх хөтөлбөр	2014	үгүй	тийм
17	Аж ахуй эрхлэх, бичил бизнесийг дэмжих хөтөлбөр	2016	тийм	үгүй
18	40-өөс дээш болон ахмад насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	2013	үгүй	үгүй
19	40-өөс дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	2014	үгүй	тийм
20	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ төсөл	2014, 2016	2014 онд үгүй	үгүй
21	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	2017-2020	тийм	үгүй

22	Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	2021	тийм	тийм
23	Эзэнтэй монгол хөтөлбөр	2013, 2014	2014 онд үгүй	үгүй
24	Нийтийг хамарсан ажил зохион байгуулах	2016	тийм	үгүй
25	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	2014, 2016, 2021	2014 онд үгүй	үгүй,
26	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	2017, 2018, 2019-2020	тийм	үгүй
27	Оюутны хөдөлмөр эрхлэлт ба цагийн ажил хөтөлбөр	2014	үгүй	тийм
28	Залуучууд, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	2015	тийм	үгүй

Эх сурвалж: ХЭД хөтөлбөрүүд

ХЭД хөтөлбөрт үнэлгээ хийхэд мэдээлэл хангалтгүй, хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт тодорхойгүй, хүрэх үр дүнгийн үзүүлэлтээ тоогоор илэрхийлээгүй, хөтөлбөрийг хэрэгжүүлсэн үр дүнг тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал байхгүй гэх мэт учир дутагдлууд байна. Тиймээс олон улсын болон дотооддоо өргөн хэрэглэдэг нийтлэг аргачлалыг ашиглан үнэлгээ хийлээ.

3

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙН ҮНЭЛГЭЭ

2012-2021 онд хэрэгжүүлсэн ХЭД хөтөлбөрт Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” болон олон улсад нийтлэг хэрэглэдэг Эдийн засгийн хамтын ажиллагаа ба хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-ын төслийн үнэлгээний аргачлал, Сингапур болон АХБ-ны ерөнхий үнэлгээний аргачлал ашиглан хөндлөнгийн үнэлгээ хийв.

ХҮСНЭГТ 6. ХЭД хөтөлбөрийн хэрэгжилтийн ерөнхий үнэлгээ

№	Үнэлгээний шалгуур	Үнэлгээний хэмжээс	Өгсөн үнэлгээ
1	Ач холбогдол	<ul style="list-style-type: none">Өндөр ач холбогдолтойАч холбогдолтойАч холбогдол багатайАч холбогдолгүй	Өндөр ач холбогдолтой
2	Үр дүн	<ul style="list-style-type: none">Үр дүнтэйТодорхой үр дүнд хүрсэнЭрчимжүүлэх шаардлагатайҮр дүнгүй	Эрчимжүүлэх шаардлагатай
3	Үр ашиг	<ul style="list-style-type: none">Өндөр үр ашигтайҮр ашигтайҮр ашиг багатайҮр ашиггүй	Үр ашигтай
4	Хөтөлбөрийн төлөвлөлт ба бодит гүйцэтгэл	<ul style="list-style-type: none">Төлөвлөлт бүрэн хэрэгжсэнТөлөвлөлт тодорхой түвшинд хэрэгжсэнХэрэгжилт хангалтгүйХэрэгжээгүй	Төлөвлөлтийн хэрэгжилт хангалтгүй

ХЭД хөтөлбөрийн хэрэгжилтийг дээрх хүснэгтийн дагуу ач холбогдол, үр дүн, үр ашиг, хөтөлбөрийн төлөвлөлт ба бодит гүйцэтгэлд үнэлгээ өгч, дүгнэлт гаргав.

Мөн ХЭД хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцдог сургалтын байгууллага, хөдөлмөрийн хувийн бирж, аж ахуй эрхлэх сургалт зохион байгуулагч, бизнесийн зөвлөгөө өгдөг байгууллага болон хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын ажилтнуудаас анкетын аргаар судалгааны асуулга боловсруулан ХЭД хөтөлбөрийн хэрэгжилтийг хэрхэн үнэлж байгаа талаар судалгаа авав. Энэхүү судалгаанд төрийн байгууллагын 110, хувийн хэвшлийн 55 хүн оролцов.

3.1. ХЭД ХӨТӨЛБӨРИЙН АЧ ХОЛБОГДОЛ

ХЭД хөтөлбөр 2012 оноос хэрэгжиж эхэлсэн тул 2011 оны хүн амын тоо, ажиллагсдын тоо, бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоог суурь үзүүлэлт болгон ХЭД хөтөлбөрийн ач холбогдлыг үнэлэв.

2012 оноос хойш хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд тусгагдсан ХЭД арга хэмжээг зорилтот бүлэг /оюутан, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ажилгүй иргэн, ахмад мэргэжилтэн, малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажил олгогч/ тус бүрийн онцлогт тохируулан хэрэгжүүлэх, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилготой.

ХЭД хөтөлбөр хэрэгжсэн 10 жилийн хугацаанд 2011 оны суурь үзүүлэлт хэрхэн өөрчлөгдсөнийг 2021 оны үзүүлэлттэй харьцуулан харуулав. /Хүснэгт 7/

ХҮСНЭГТ 7. 2011, 2021 оны хөдөлмөр эрхлэлтийн статистик үзүүлэлтүүд

Д/Д	Аймаг/ Нийслэл	Нийт хүн амын тоо				Ажиллагчдын тоо				Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо			
		2011		2021		2011		2021		2011		2021	
		Тоогоор	Хувиар	Тоогоор	Хувиар	Тоогоор	Хувиар	Тоогоор	Хувиар	Тоогоор	Хувиар	Тоогоор	Хувиар
1	Архангай	84,355	94,205	9,850	11.7%	46,969	36,257	-10712	-22.8%	2,584	639	-1945	-75.3%
2	Баян-Өлгий	88,772	112,836	24,064	27.1%	42,005	33,550	-8455	-20.1%	1,038	709	-329	-31.7%
3	Баянхонгор	76,651	89,043	12,392	16.2%	34,537	30,483	-4054	-11.7%	1,309	1,332	23	1.8%
4	Булган	54,117	61,943	7,826	14.5%	24,863	25,868	1005	4.0%	597	429	-168	-28.1%
5	Говь-Алтай	52,970	57,818	4,848	9.2%	24,440	20,335	-4105	-16.8%	597	668	71	11.9%
6	Дорноговь	60,206	71,457	11,251	18.7%	20,171	26,236	6065	30.1%	656	372	-284	-43.3%
7	Дорнод	70,214	83,757	13,543	19.3%	25,774	30,799	5025	19.5%	1,756	1,095	-661	-37.6%
8	Дундговь	37,726	46,920	9,194	24.4%	22,283	20,437	-1846	-8.3%	638	263	-375	-58.8%
9	Завхан	64,224	72,731	8,507	13.2%	30,095	27,585	-2510	-8.3%	1,457	771	-686	-47.1%
10	Өвөрхангай	101,211	115,732	14,521	14.3%	44,019	50,453	6434	14.6%	2,099	374	-1725	-82.2%
11	Өмнөговь	63,426	71,720	8,294	13.1%	24,506	26,602	2096	8.6%	705	352	-353	-50.1%
12	Сүхбаатар	51,782	64,662	12,880	24.9%	24,729	28,260	3531	14.3%	859	563	-296	-34.5%
13	Сэлэнгэ	99,240	108,878	9,638	9.7%	45,101	18,259	-26842	-59.5%	1,135	488	-647	-57.0%
14	Төв	85,705	93,468	7,763	9.1%	45,313	35,725	-9588	-21.2%	854	595	-259	-30.3%
15	Увс	72,984	84,095	11,111	15.2%	36,553	48,149	11596	31.7%	781	840	59	7.6%
16	Ховд	77,224	91,127	13,903	18.0%	34,746	35,501	755	2.2%	2,132	549	-1583	-74.2%
17	Хөвсгөл	115,934	136,794	20,860	18.0%	49,048	47,256	-1792	-3.7%	2,417	305	-2112	-87.4%
18	Хэнтий	66,447	78,967	12,520	18.8%	26,198	35,542	9344	35.7%	1,365	443	-922	-67.5%
19	Дархан-Уул	96,031	107,751	11,720	12.2%	36,843	28,276	-8567	-23.3%	1,907	933	-974	-51.1%
20	Орхон	91,488	108,713	17,225	18.8%	32,780	31,675	-1105	-3.4%	2,287	1,576	-711	-31.1%
21	Говьсүмбэр	13,859	18,150	4,291	31.0%	5,303	6,601	1298	24.5%	477	36	-441	-92.5%
22	Улаанбаатар	1,287,100	1,639,172	352,072	27.4%	361,404	984,106	622702	172.3%	29,331	10,343	-18988	-64.7%
23	Нийт	2,811,666	3,409,939	598,273	21.3%	1,037,680	1,627,955	590,275	56.9%	56,981	23,675	-33,306	-58.4%

Эх сурвалж: www.1212.mn, УСГ, ХНХЯ-ны сар бүрийн мэдээ


Хамгийн өндөр өсөлттэй

Хамгийн бага өсөлттэй ба бууралттай

Хүснэгт 7-оос харахад 2011-2021 онд ХЭД хөтөлбөр хэрэгжсэнээр бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо улсын хэмжээнд 33,306 хүнээр буюу 58.4%-иар буурсан байна. Мөн улсын хэмжээнд хүн амын тоо 598,273 буюу 21.3%-иар өсч, ажиллагчдын тоо 590,275 буюу 56.9%-иар тус тус өссөн байна. Улаанбаатар хотын хэмжээнд ажлын байр илүү нэмэгдэж, ажиллагчдын тоо 622,702 буюу 172.3%-иар нэмэгдсэн нь улсын хэмжээнд ажиллагчдын тоо өсөхөд нөлөөлсөн байна. Бусад аймаг орон нутагт ажиллагчдын тоо дорвитой нэмэгдээгүй ба ихэнх аймагт буурсан үзүүлэлттэй байна. /Зураг 9/

2011 оныг 2021 онтой харьцуулсан үзүүлэлтээр хүн амын тоогоор хамгийн өндөр өсөлттэй 3 аймаг нь Говьсүмбэр аймаг 4,291 хүнээр буюу 31%-иар, Улаанбаатар хот 352,072 хүнээр буюу 27.4%-иар, Баян-Өлгий аймаг 24,064 хүнээр буюу 27.1%-иар, хамгийн бага өсөлттэй 3 аймаг нь Сэлэнгэ аймаг 9,638 хүнээр буюу 9.7%-иар, Говь-Алтай аймаг 4848 хүнээр буюу 9.2%-иар, Төв аймаг 7,763 хүнээр буюу 9.1%-иар тус тус өссөн байна. Ажиллагчдын тооны хамгийн өндөр өсөлттэй нь Улаанбаатар хот 622,702 хүн буюу 172.3%, Хэнтий аймаг 9,344 хүн буюу 35.7%, Увс аймаг 11,596 хүн буюу 31.7%, хамгийн их бууралттай нь Сэлэнгэ аймаг буюу (-26,842) хүн буюу (-59.5%), Дархан-Уул аймаг (-8,567) хүн буюу (-23.3%), Архангай аймаг (-10,712) хүн буюу (-22.8%) байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо өссөн 3 аймаг нь Говь-Алтай аймаг 71 хүнээр буюу 11.9%-иар, Увс аймаг 59 хүнээр буюу 7.6%-иар, Баянхонгор аймаг 23 хүнээр буюу 1.8%-иар, хамгийн их бууралттай нь Говьсүмбэр аймаг (-441) хүнээр буюу (-92.5%)-иар, Хөвсгөл аймаг (-2,112) хүнээр буюу (-87.4%)-иар, Өвархангай аймаг (-1,725) хүнээр буюу (-82.2%)-иар байна.

ЗУРАГ 9. 2011-2021 оны хүн ам, хөдөлмөрийн статистик үзүүлэлтийн өөрчлөлт /хувиар/



Эх сурвалж: ҮСХ, ХНХЯ-ны сар бүрийн мэдээ


ХЭД хөтөлбөр хэрэгжиж эхэлснээр бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо буурч ажиллагчдын тоо нэмэгдсэн эерэг үзүүлэлт гарсан ч орон нутагт ажлын байр нэмэгдэхгүй, хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн их, ажиллах хүчний байршил Улаанбаатар хотод төвлөрч байгаа нь хөдөлмөр эрхлэлтийн бодлогын зорилгыг **орон нутагт хандуулах хэрэгцээ шаардлагатай** болсныг харуулж байна.

Ажил идэвхтэй хайгч буюу бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо буурсныг ажлын байр нэмэгдсэн гэж тооцож болохгүй. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо буурсан нь ажилгүй иргэд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг авахын тулд хаана очихоо мэдэхгүй, мэдээлэл дутмаг, ажил хайсан ч сайн ажил олддоггүйтэй холбоотой байна. Түүнчлэн хөдөлмөрийн үнэлэмж бага бөгөөд хувиараа хөдөлмөр эрхлэх, онлайн бизнес эрхлэх, албан бус хөдөлмөр эрхлэх боломж нэмэгдсэнтэй шууд холбоотой байна.

Хөдөлмөрийн насны хүн амын тоо өсөж байхад ажиллагчдын тоо, бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо буурч байгаа нь ажилгүй иргэд ажил эрхлэх сонирхол багатай, ажил болон цалин хөлс голох хандлага зонхилж байгааг илэрхийлж байна. Ялангуяа орон нутагт бэлэн ажлын байранд ажиллах хүн олдохгүй байна хэмээн ХХҮГ-ийн мэргэжилтнүүд үзэж байв. Энэ нь төрөөс үзүүлэх хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зайлшгүй шинэчлэх шаардлага үүссэнийг илтгэж байна.

Манай улсын хөдөлмөр эрхлэлтэд хүн амын тоо, нас, хүйс, бүс нутгийн онцлог, хүн амын нягтшил, хүн амын боловсролын түвшин, эрүүл мэнд, үйлдвэрлэл, гадаад харилцаа гэх мэт олон хүчин зүйл нөлөөлдөг. 2011 оны хүн амын нас хүйсийн суваргаас харвал 20-24 насны буюу суралцах насны хүн ам хамгийн их байсан бол 2021 онд 30-34 насны буюу ажиллаж, хөдөлмөрлөх насны хүн ам хамгийн их байна. /Зураг 10/

ЗУРАГ 10. 2011, 2021 оны хүн амын нас, хүйсийн суварга




Эх сурвалж: 1212.mn, ҮСХ

Хүн амын суваргаас харвал 10 жилийн өмнө хөдөлмөрийн зах зээлд шинээр орж байсан залуучуудад хандсан хөдөлмөрт бэлтгэх үйлчилгээ илүү ач холбогдолтой байсан. Оролцогч талуудаас авсан судалгаагаар хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр илүү сайн хэрэгжсэн гэж үзсэн байна. Харин 2022 оны байдлаар хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй байна. Иймд цаашид хүн амын насны бүтэцтэй уялдуулж хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг уян хатан төлөвлөх шаардлагатай байна.

Ажиллагчдын 82.7 (7.3%) мянга нь 15-24 насныхан (боловсрол, сургалтын дараах хөдөлмөрийн зах зээлд шинээр орж байгаа залуучууд), 937.2 (83.2%) мянга нь 25-54 насныхан (ерөнхий ажиллах хүчний насныхан), 92.9 (8.2%) мянга нь 55-64 насныхан (тэтгэвэрт гарахад ойрхон байгаа) болон 14.3 (1.3%) мянга нь 65 ба түүнээс дээш насныхан байна. /Зураг 11/

ЗУРАГ 11. Хөдөлмөрийн статистикийн үзүүлэлтүүд, 2021 оны 4 дүгээр улиралд




Эх сурвалж: ХНХСИ, Ажиллах хүчний судалгаа 2021


Нийт ажиллагчдын 607.9 (53.9%) мянга нь үйлчилгээний, 277.8 (24.7%) мянга нь хөдөө аж ахуйн салбарт, 241.4 (21.4%) мянга нь үйлдвэрлэлийн салбарт ажиллаж байна.

Ажиллах хүч, бүртгэлтэй ажилгүй иргэд, ажилгүйдэл ядуурлын түвшний динамик өөрчлөлтийг доорх зураг 12-14-т харуулав.


ЗУРАГ 12. Ажиллах хүчний үзүүлэлт мян.хүн /2011-2021/



ЗУРАГ 13. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо /мян.хүн/



ЗУРАГ 14. Ажилгүйдэл, ядуурлын түвшин /2010-2020/



Мэдээллийн эх үүсвэр www.1212.mn ҮСХ, www.worldbank.org ХЭВЛЭЛИЙН МЭДЭЭ

2012 онд ХЭД арга хэмжээг хөтөлбөрт суурилсан байдлаар баталж, хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаа эрчимжиж, иргэдэд өгөх мэдээлэл, сурталчилгааг сайн хийж, олон нийтэд мэдээлэл хүргэснээр бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо өссөн байна. Гэвч 2013 оноос хойш нийт ажилгүй иргэдийн тоо өссөн ч бүртгэлтэй ажилгүй иргэний тоо буурсан байна.

2016 онд ажилгүйдэл, ядуурал макро түвшинд хамгийн их байх үед ХЭД 8 хөтөлбөр баталж, 22 арга хэмжээ хэрэгжүүлж, 18,7 тэрбум төгрөг зарцуулсан байна. Энэ нь 2015 оноос 36.4%-иар бага, 2017 оноос 29.9%-иар бага зарцуулсан үзүүлэлт юм. Эндээс үзэхэд ХЭД хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө багасах үед ажилгүйдэл ядуурлын түвшин нэмэгдсэн байх уялдаа байж болохоор байна. ХЭД хөтөлбөр ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад тодорхой хэмжээгээр нөлөөлжээ гэж үзэж болох юм. Нөгөө талаас, удаан хугацаагаар ажилгүй байсан хүн, мэргэжил, ур чадвар эзэмшээгүй хүн, ХБИ, эмэгтэйчүүд, ахмадуудын хувьд хөдөлмөрийн зах зээлд нэвтрэхэд хамгийн бэрхшээлтэй байдаг бүлгүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг багцлан тусгай хөтөлбөр болгон хэрэгжүүлж байсан нь тухайн үед **өндөр ач холбогдолтой** байсан гэж үнэлэв.

3.2. ХЭД ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮН


ХЭД арга хэмжээг ажилгүй иргэд ялангуяа хөдөлмөрийн зах зээлд шууд нэвтрэхэд хүндрэлтэй Хөгжлийн бэрхшээлтэй иргэн (ХБИ), ахмад настан, залуучууд, удаан хугацаагаар ажилгүй байгаа иргэн зэрэг хүн амын зорилтот бүлгийн иргэдэд хандуулах шаардлагатай байсан тул хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээг хөтөлбөрт суурилсан байдлаар хэрэгжүүлэхээр 2012 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд тусгасан.

ХЭД тухай хуулийн 7 дугаар зүйлд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд ажил хайгч, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, малчин, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн, ажил олгогч хамрагдахаар заасан байдаг. ХЭҮЗ-өөр баталж, хэрэгжүүлсэн ХЭД хөтөлбөрүүдэд дараах иргэдийг хамруулахаар заасан байсан. Үүнд:

1. Ажилгүй иргэн
2. Ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн
3. Ажил олоход хүндрэлтэй иргэн
4. Ажил хайгч иргэн
5. Сургууль завсардсан
6. Хөдөлмөрийн насанд хүрсэн хүүхэд
7. Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн
8. Дагалдан шавь гэрээтэй малчид
9. Малчин, малчин өрх, малчин ажил олгогч
10. Хорих ангиас суллагдсан иргэн
11. Хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан иргэн
12. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай гишүүн
13. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
14. 6 сараас дээш хугацаагаар ажил олж чадахгүй байгаа иргэн
15. Ажил олгогч байгууллага
16. Иргэн, аж ахуйн нэгж, бичил бизнес, нөхөрлөл, хоршоо
17. Оюутан
18. Бизнес эрхлэгч залуучууд
19. Ажил идэвхтэй хайж байгаа залуучууд
20. Ахмад настан
21. Орон нутгийн иргэдийн бүлэг
22. Бизнес инкубаци
23. Ахмад мэргэжилтэн
24. Төрийн бус байгууллага, холбоо, мэргэжлийн байгууллага
25. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид
26. Байнгын асаргаанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг, эх
27. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангаж буй ажил олгогч

ХЭД хөтөлбөрийн хамрах хүрээг авч үзвэл нийт 27 зорилтот бүлэг байгаагаас халамжийн тэтгэмж авах нөхцөлийг хангасан 5 зорилтот бүлэг байна. Үүнээс 2 зорилтот бүлэг нь нийгмийн халамжаас 1 удаагийн тэтгэмж авах эрхтэй зорилтот бүлэг байна. Нийт ХЭД 28 хөтөлбөр хэрэгжсэнээс “Халамжаас-Хөдөлмөрт шилжих бодлого”-ын зорилтод нийцсэн, зорилтот бүлэгт чиглэсэн 4 хөтөлбөр байна. Үүнд: Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр, Ажлын байрыг дэмжих хөтөлбөр, ХБИ-ий хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр (2014-2020 онд ХБИ-ий ажлын байрыг дэмжих хөтөлбөр нэртэйгээр хэрэгжсэн) байна /Зураг 15/.

ЗУРАГ 15. Халамжаас хөдөлмөрт шилжих бодлогыг тусгасан ХЭД хөтөлбөр



10 жилийн хугацаанд хэрэгжсэн ХЭД 28 хөтөлбөрийн 4 нь буюу 14.2%, 27 зорилтот бүлгийн 5 нь буюу 18.5% нь “Халамжаас Хөдөлмөрт шилжих бодлого”-ын зорилтыг хэрэгжүүлэх зорилтот бүлэгт чиглэсэн байна.

Зорилтот бүлгүүдээс ХБИ-ий хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоосон Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрийг үндэслэж үйлчилгээ үзүүлэхээс бусдаар зорилтот бүлгийг баталгаажуулах, шалгах ямар нэгэн бичиг баримт шаарддаггүй. Иргэний үнэмлэхний хуулбараар арга хэмжээнд хамрагдсаныг баталгаажуулж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд ХЭД хөтөлбөрт ажилгүй иргэдийг хамруулахаар заасан. ХЭД хөтөлбөрийн хамрах хүрээг харахад хөдөлмөрийн зах зээлд шууд нэвтрэхэд бэрхшээлтэй, удаан хугацааны сургалт, зөвлөгөө, үйлчилгээ, арга хэмжээ шаардлагатай иргэдэд голдуу чиглэсэн байна. Харин бүтцийн ажилгүйдэл, түр ажилгүйдэлд өртсөн, хөдөлмөр эрхлэлтийн дэмжлэг, нэмэлт үйлчилгээ авснаар хөдөлмөрийн зах зээлд оролцоход бэлэн ажил хайгчдад чиглэсэн хөтөлбөр дутмаг байна.

ХЭД хөтөлбөрийг жил бүр шинэчлэн батлахдаа хамрагдах зорилтот бүлгийг тодорхой зааж, батлагдсан төсөвт багтаан хамруулах хүний тоог хөтөлбөр тус бүрээр аймаг, дүүргээр хуваарилж өгдөг. Зарим хөтөлбөрт хамруулах хүний тооны квот хэт цөөн ирдэг учраас тухайн хөтөлбөрт хамрагдах шаардлага хангасан, хүссэн хүн бүрийг хамруулах боломжгүй байдаг байна. Нөгөө талаас зарим орон нутагт тухайн хөтөлбөрт хамруулахаар заасан зорилтот бүлгийн иргэд (хорих ангиас суллагдсан, асрамжийн газраас гарсан иргэн, ХБИ гэх мэт)-ийн тоо цөөн учраас нэг хөтөлбөрт давтан хамрагдах эсхүл олон хөтөлбөрт зэрэг хамрагдах нөхцөл үүсдэг байна.

ШИГТГЭЭ 1.**Дорноговь аймгийн Айраг сумын малчин Ш.Баяржаргал, 42 настай:**

2019 онд өөрийн 20 гаруй үхэртэй байсан. Малчны ХЭД хөтөлбөрт хамрагдаж, 4.0 сая төгрөгөөр 10 хургатай хонь, 18 ишигтэй ямаа нийт 28 эх мал худалдаж авсан. Энэ жил авсан дэмжлэгийнхээ сүүлийн эргэн төлөлтийг хийнэ. Төлбөр тооцоогоо хуваарийн дагуу төлөөд явж байгаа, хавар ашиг шимээ аваад ирэхээрээ төлөлтөө хийдэг. Өмнө нь хамрагдах гэж хөөцөлдөж байсан ч насны хязгаарт ороод авч чаддаггүй байсан. Бог малтай болох зорилгоор малжуулах төсөлд хүсэлтээ өгөөд хамрагдсан. Хавар мал туранхай байдаг. 8 сард малаа худалдаж авах нь цаг хугацааны хувьд тохиромжтой санагдсан. Одоо манай өрх 33 үхэр, 8 адуу, 250 гаруй хонь ямаатай болсон. Зорьж авч байгаа хүнд үр өгөөжтэй, сайн хөтөлбөр гэж боддог.

Айраг суманд уул уурхайн лиценз авсан гээд энд тэндгүй газар ухаад малчид бэлчээргүй болж, шахагдаж байна.

Орхон аймгийн ХХҮГ-ын мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагаас:

Орхон аймаг нь төвлөрсөн хот суурин газар учраас бэлчээргүй. Үүнээс болоод малжуулах хөтөлбөрт хамрагдахын тулд гэр бүлийн нэг гишүүн нь заавал Булганы харъяат байх ёстой болдог. Тодорхой хугацаанд үр дүнтэй байсан, одоо бол малжуулах хөтөлбөрийг зогсоох саналтай байна.

Өвөрхангай аймгийн ХХҮГ-ын мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагаас:

Малжуулах хөтөлбөр үр дүнтэй. Малчдын дийлэнх нь 40-өөс дээш насных болсон. Малчдын тоо багасаж байна. Иймд цөөн малтай залуу малчдыг дэмжих нь чухал байна. Малын тоог 150 болгоод бодыг богт шилжүүлэн тооцож байгаа нь хэрэгжүүлэхэд төвөгтэй болсон. Энэ жил 2022 онд 100 хүний квот өгсөн. Сүүлийн 2 жил зуд болсон учраас энэ жил сум бүрээс хамрагдах санал их ирүүлсэн. Аймгийн ХЭЗ-өөс говийн 4 сумын малчдаа түлхүү хамруулья гэж шийдэн, нийт квотын 50%-ийг хуваарилсан.

Гэрээт малчин хөтөлбөр бараг хэрэгжилтгүй. Гол шалтгаан нь бэлэнчлэх сэтгэлгээ хэтэрхий хавтгайрсан, хөшүүрэг бага байна, төв суурин газар нэгэнт ирчихсэн хүн буцаад хөдөө явдаггүй юм байна, хүний захиргаанд ажиллахыг ч хүсдэггүй юм байна. Судалгаа авахад 70 гаруй гэрээт малчин авах шаардлагатай гэж малчдаас захиалга ирсэн боловч гэрээт малчнаар явах хүн аймгаас олдоогүй.

Түүнчлэн хөтөлбөрт хамрагдах хүний тооны квот заадаг учраас иргэн ХХҮГ\Х-т оны эхэнд хандсан тохиолдолд олон хөтөлбөрүүдэд хамрагдах боломжтой бөгөөд оны эцэст мэдээлэл, үйлчилгээ авсан иргэн ихэвчлэн дараа жил хөтөлбөр зарлагдаж квот хуваарилагдаж ирэхийг хүлээдэг байна. Цаашид хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, ХЭД хөтөлбөрт хамрагдсан **нэг иргэнийг нэг бүртгэлээр** буюу регистрийн дугаараар нь түүх үүсгэн ХЗЗ-ийн мэдээллийн системд бүртгэлжүүлэх шаардлагатай юм.

ХЭД хөтөлбөрийн хамрах хүрээ хязгаарлагдмал байгаагаас нэг хүн хэд хэдэн хөтөлбөрт олон дахин хамрагдах эсхүл хөтөлбөрт хамрагдах эрэлт хэрэгцээтэй хэсэг нь квот бага гэдэг

шалтгаанаар хөтөлбөрт хамрагдаж чадахгүй нь ХЭД хөтөлбөрийг үр дүнгүй болгож байгаа гэж шалтгаан болж байна.

3.2.1. ХЭД үндсэн хөтөлбөр ба арга хэмжээнүүд

2012 оноос хойш өнгөрсөн 10 жилийн хугацаанд нийтдээ 28 өөр нэр бүхий ХЭД хөтөлбөр, тэдгээрийн хүрээнд 64 төрлийн арга хэмжээг баталж, хэрэгжүүлсэн боловч ихэнх хөтөлбөрүүд агуулгын хувьд давхацсан буюу үндсэн 7 төрлийн ХЭД хөтөлбөрийг хэрэгжүүлж байжээ. Үүнд 1) Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр, 2) ХБИ-ний ХЭД хөтөлбөр, 3) Ажлын байрыг дэмжих хөтөлбөр, 4) Нийтийг хамарсан ажил зохион байгуулах хөтөлбөр, 5) Ахмадын ХЭД хөтөлбөр, 7) Залуучуудын ХЭД хөтөлбөр орж байна. Эдгээр хөтөлбөрүүдийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээг ерөнхий агуулгаар нь багцалбал, дараах 6 бүлэг арга хэмжээнд хуваагдахаар байна:

Үүнд:

- 1) Сургалт;
- 2) Нийтийг хамарсан ажил;
- 3) Санхүүгийн дэмжлэг;
- 4) Залуучуудын гарааны бизнесийг дэмжих;
- 5) Ажилд зуучлах үйлчилгээ;
- 6) Бусад гэсэн ерөнхий арга хэмжээнүүдтэй байна.

ХЭД хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэхдээ дээрх үндсэн арга хэмжээнүүдийн хэрэгжилт, гүйцэтгэлд тулгуурлав.

1) Сургалт зохион байгуулах арга хэмжээ

ХЭД хөтөлбөрийн арга хэмжээнд дүн шинжилгээ хийж тухайн арга хэмжээ ямар хугацаанд хэдэн хөтөлбөрт тусгагдаж хэрэгжсэнийг дараах графикаар харуулав. /Зураг 16/


ЗУРАГ 16. Сургалт зохион байгуулах арга хэмжээний хэрэгжилтийн давтамж




Эх сурвалж: ХЭД хөтөлбөр

ХЭД хөтөлбөрт 5 төрлийн сургалт буюу аж ахуй эрхлэлт, мал маллах арга ухаан, мэргэжил олгох, үйлдвэрлэл дээрх сургалт, хөдөлмөрт бэлтгэх сургалтын төрлүүд тусгагдсан байна. Үүнээс мал маллах арга ухааны сургалт 8 жил, бусад нь 10 жил хэрэгжсэн байна. Сургалтуудад хамрагдсан хүний тоог сүүлийн 5 жилээр харуулав /Зураг 17-20/.

ЗУРАГ 17. Аж ахуй эрхлэлтийн сургалт



ЗУРАГ 18. Мал маллах арга ухааны сургалт



Эх сурвалж: ХНХЯ-ны ХЭБХЗГ-ын мэдээ, тайлан


Аж ахуй эрхлэлтийн сургалт нь төсөл, хөтөлбөр боловсруулах, бизнесийн санаагаа эхлүүлэх, бизнесээ хөгжүүлэх ОУХБ-ын хөтөлбөрт сургалт, маркетинг борлуулалт, хоршооны сургалт, бүлэг зохион байгуулах гэх мэт сургалтыг хамрах бөгөөд хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, ХБИ-ий ажлын байрыг дэмжих хөтөлбөр, аж ахуй эрхлэх, бичил бизнесийг дэмжих хөтөлбөр, ажлын байрыг дэмжих хөтөлбөр, залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр, цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр гэсэн 7 хөтөлбөрт тусгагдсан байна.

Мал маллах арга ухааны сургалт малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг хөтөлбөрт тусгагдсан байна.

ЗУРАГ 19. Хөдөлмөр эрхлэлтийн сургалт



ЗУРАГ 20. Хөдөлмөрт бэлтгэх сургалт



Мэргэжил олгох сургалтад мэргэжлийн болон давтан, явуулын сургалт, зайны, шавь сургалт гэх зэрэг танхимын сургалтыг хамааруулж авч үзсэн бөгөөд Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр, Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах хөтөлбөр, Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр, Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, Ажлын байр хадгалах хөтөлбөр, Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, ажлын байрыг дэмжих хөтөлбөр, Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөр, ХБИ-ий хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, 40-өөс дээш болон Ахмад насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр

гэсэн 7 хөтөлбөрт тусгагдсан байна.

Үйлдвэрлэл дээрх сургалт зохион байгуулах арга хэмжээ нь Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр, Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах хөтөлбөр, Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр, Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, ажлын байр хадгалах хөтөлбөр, Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, ажлын байрыг дэмжих хөтөлбөр, Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөр, ХБИ-ий хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, Ажил олгогчийг дэмжих хөтөлбөр гэсэн 7 хөтөлбөрт тусгагдсан байна.

Хөдөлмөрт бэлтгэх сургалтад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, хөдөлмөр эрхлэлтийн зөвлөгөө мэдээлэл өгөх сургалт, ХАБЭА-н сургалт, сэтгэлзүйн, хөдөлмөрийн харилцааны гэх мэт сургалтуудыг хамааруулна. Энэхүү сургалт нь Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр, Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах хөтөлбөр, Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр, Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, ажлын байр хадгалах хөтөлбөр, Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, ажлын байрыг дэмжих хөтөлбөр, Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөр, ХБИ-ий хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, 40-өөс дээш болон Ахмад насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, оюутны хөдөлмөр эрхлэлт ба цагийн ажил хөтөлбөр, Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээг дэмжих хөтөлбөр гэсэн 9 хөтөлбөрт тусгагдсан байна.

Дээрх 5 төрлийн сургалтад иргэн хамрагдахын тулд аймаг, дүүргийн ХХҮГ/Х-т бүртгүүлж дараалалд ордог бөгөөд тухайн сургалт зохион байгуулагдах үед сургалтад суун шалгалтаа амжилттай өгснөөр мэргэжлийн үнэмлэх эсвэл гэрчилгээтэй төгсдөг. /Зураг 21/.

ЗУРАГ 21. Иргэн сургалтанд хамрагдах процесс



Эх сурвалж: ХХҮГ/Х-ийн мэргэжилтнүүдийн ярилцлага

ХХҮГ/Х-т хандсан иргэн ажил мэргэжлийн чиг баримжаа олгох мэргэжилтнээс зөвлөгөө мэдээлэл авч бүртгүүлээд дараагийн шатны ямар сургалтад хамрагдахаа сонгоно. Хөдөлмөрт бэлтгэх, аж ахуйн эрхлэлтийн сургалтууд 3-5 хоног, мэргэжил олгох, үйлдвэрлэл дээрх дадлагын сургалт, мэргэжлийн төрлөөсөө шалтгаалаад 14-45 хоног үргэлжилдэг байна.

Мэргэжлийн сургалтын төрөлд 5 салбарын 60 мэргэжил байна. Үүнээс ихэнх нь явагддаггүй, явуулах сургалтын байгууллага байдаггүй. Гар утасны засвар, хүнд машин механизмын оператор гэх мэт эрэлт хэрэгцээ өндөртэй мэргэжлийн сургалтууд хязгаарлагдмал квоттой байдаг тул иргэд хүссэн сургалтдаа хамрагдах боломж хомс байдаг.


ШИГТГЭЭ 2.

Өвөрхангай аймгийн ХХҮГ-ын мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагаас:

Мэргэжил олгох сургалтын дундаж тариф 240.0 мянган төгрөг байна. Ийм зардлаар орон нутагт ирж чанартай сургалт зохион байгуулах мэргэжлийн сургалтын байгууллага олддоггүй. Олдсон байгууллага нь зардалд нь тохируулан нийтлэг, байнга ордог сургалт ороод явдаг. Сургалтын байгууллагууд 10-15 хүний анги дүүргэлттэй тохиолдолд орон нутагт ирж, сургалт явуулна гэсэн шаардлага тавьдаг. Гэтэл аймагт жил бүр 15 тогооч бэлтгэж сургаад байх бодит хэрэгцээ бага байна. Гэтэл хүнсний ногооны хүлэмжийн тариалалт гэх мэт шинэ чиглэлээр сургалтын хэрэгцээ их байна. Үйлдвэрлэл дээрх сургалтыг анги дүүргэлт гэхгүйгээр 1-2 хүнийг ч гэсэн сургалтад хамруулаад ажил олгогчид мөнгийг нь өгдөг болох хэрэгтэй. Учир нь 15-20 хүн сургаж, ажиллуулах чадавхтай ААН орон нутагт байхгүй.


Сургалтын арга хэмжээний хамрагдах хүрээ болон санхүүжилтийн гүйцэтгэлийг сүүлийн 5 жилээр зураг 22, 23-т харуулав.

ЗУРАГ 22. Сургалт зохион байгуулах арга хэмжээ /хүний тоогоор/



Эх сурвалж: ХНХЯ-ны ХЭБХЗГ-ын мэдээ, тайлан

ЗУРАГ 23. Сургалт зохион байгуулах арга хэмжээний санхүүжилт /мян.төг/



Эх сурвалж: ХНХЯ-ны ХЭБХЗГазрын мэдээ, тайлан

Сургалт зохион байгуулах арга хэмжээ нь хүний тооны хувьд хамгийн сайн буюу 89.5-100%-ийн гүйцэтгэлтэй, төсвийн гүйцэтгэлийн хувьд 62.8-86.2%-ийн гүйцэтгэлтэй байна.

ХЭД хөтөлбөрийн сургалтын арга хэмжээ нь байнгын давтамжтай хэрэгждэг ба нийт төсвийн 3-7.5%-ийг эзэлдэг байна. Харин нийт хөтөлбөрт хамрагдсан иргэдийн тоогоороо 30-45%-ийг эзэлж байна. Манай улсын уур амьсгал, газарзүйн онцлог, үйлдвэрлэлийн салбарын онцлог, бүтээн байгуулалт, улсын хэмжээнд хэрэгжиж буй хөтөлбөр төслүүдтэй холбоотойгоор улирлын шинжтэйгээр 4-5 дугаар сард хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нэмэгддэг. Оролцогч талуудын судалгаагаар сургалтыг 3-4 дүгээр сард зохион байгуулах нь хамгийн үр дүнтэй гэж үзсэн.

Сургалт нь тасралтгүй явагдах шаардлагатай тул байнга хэрэгжүүлэх арга хэмжээ болгож ХЭД хөтөлбөрөөс салгах саналтай байна.

Сургалтын арга хэмжээний гүйцэтгэл, үр дүнг зөвхөн төсвийн гүйцэтгэлээр үнэлэх нь хангалтгүй. Цаашид чанарын үнэлгээ хийгдэх шаардлагатай.

2) Нийтийг хамарсан ажил зохион байгуулах арга хэмжээ

Энэхүү нийтийг хамарсан ажил зохион байгуулах арга хэмжээ нь түр ажлын байрыг бий болгодог бөгөөд ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ, бүлгийн зохион байгуулалттай ногоо тариалах гэх мэт арга хэмжээнүүд хамаарна.

Давтамжийн хувьд 10 жилийн туршид хэрэгжсэн бөгөөд 7 хөтөлбөрт тусгагдсан байна. Үүнд:


1. Эзэнтэй монгол хөтөлбөр;
2. Нийтийг хамарсан ажил зохион байгуулах хөтөлбөр;
3. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр;
4. Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр;
5. Оюутны хөдөлмөр эрхлэлт ба цагийн ажил хөтөлбөр;
6. Залуучууд, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр

эрхлэлтийг дэмжих хөтөлбөр;


7. Ажлын байрыг дэмжих хөтөлбөрт тус тус тусгагдсан байна.

Нийтийг хамарсан ажлын гүйцэтгэлийг зураг 24, 25-т харуулав.

ЗУРАГ 24. Нийтийг хамарсан ажил /хүний тоогоор



ЗУРАГ 25. Нийтийг хамарсан ажлын гүйцэтгэл /мян.төг/



Эх сурвалж: ХНХЯ-ны ХЭБХЗГ газрын мэдээ, тайлан

Дээрх графикаас харахад нийтийг хамарсан ажлын хамрах хүрээ 2018 онд өссөн бөгөөд бусад жилүүдэд буурсан үзүүлэлттэй байна. Санхүүжилтийн хувьд ч жилээс жилд буурсан байна.

Нийтийг хамарсан ажлын санхүүжилтийг дээд тал нь 10 хоногоор тооцож хувь хүний дансанд ХАОАТ-ыг суутган шилжүүлдэг. Энэхүү арга хэмжээ нь ХХҮГ/Х тухайн орон нутгийн засаг захиргааны нэгжтэй хамтран ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлдэг байна.

Байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй бусад нөхцөл байдлын улмаас үүссэн хор уршгийг арилгах, нөхөн сэргээх, нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд бүтээн байгуулалт хийх, сайжруулах, тохижилт хийх, хог хаягдалгүй байлгах, байгаль орчныг хамгаалах, ой цэвэрлэх, мод тарих, голын ай сав, үер усны даланг цэвэрлэх, усны нөөц сан байгуулах, засварлах зэрэг үйл ажиллагааг нийтийг хамарсан ажлын хүрээнд зохион байгуулдаг.

Нийтийг хамарсан ажил нь түр ажлын байрыг бий болгоход чиглэгддэг. Ихэвчлэн хороонд бүртгэлтэй, нийгмийн идэвхтэй, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай гишүүд хамрагддаг байна. Тиймээс нийтийг хамарсан ажлыг хөтөлбөрөөс салгаж арга хэмжээ болгох саналтай байна.

3) Санхүүгийн дэмжлэгийн арга хэмжээ

Санхүүгийн дэмжлэгийн арга хэмжээнд ажлын байр шинээр бий болгох, хадгалах, хамгаалахад чиглэсэн аж ахуй эрхлэх үйл ажиллагааны төсөлд зориулж иргэн, аж ахуйн нэгжид санхүүгийн дэмжлэгийг мөнгөн хэлбэрээр олгож байгаа дараах арга хэмжээг хамруулан авч үзэв. Үүнд:

Аж ахуйн нэгжид санхүүгийн дэмжлэг үзүүлэх /эргэн төлөлттэй/

- ◆ Гэрээт малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох
- ◆ Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох/эргэн төлөлттэй, ХБИ-50%/
- ◆ Малчин өрхөд санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээ зохион байгуулах
- ◆ Өрхийн үйлдвэрлэл эрхлэхэд зориулан санхүүгийн дэмжлэг үзүүлэх /эргэн төлөлттэй/

- ◆ Төрийн бус байгууллагад санхүүгийн дэмжлэг үзүүлэх /эргэн төлөлтгүй/
- ◆ Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох
- ◆ Богино хугацааны эргэлтийн хөрөнгийн дэмжлэг олгох /fintech/
- ◆ Ажил олгогчийн урамшуулал
- ◆ Борлуулалтын дэмжлэг
- ◆ Түрээсийн хөнгөлөлт
- ◆ Цалингийн дэмжлэг гэх мэт санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээг хамааруулдаг.

Санхүүгийн дэмжлэг нь ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих, Ажлын байрыг дэмжих, Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх, Аж ахуй эрхлэх, бичил бизнесийг дэмжих, Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих, Хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих, Ажил олгогчийг дэмжих, Ажил олоход хүндрэлтэй иргэнийг ажлын байраар хангасан ажил олгогчийг дэмжих хөтөлбөр гэсэн 14 хөтөлбөрт тусгагдсан байна.

2021 онд ХЭД 5 хөтөлбөр хэрэгжсэнээс 4 хөтөлбөрт нь санхүүгийн дэмжлэгийн арга хэмжээ давтагдаж орсон байна /Зураг 26/.

ЗУРАГ 26. 2021 оны санхүүгийн дэмжлэг арга хэмжээ /ХЭД хөтөлбөрөөр/




Эх сурвалж: ХНХЯ-ны ХЭБХЗын мэдээ, тайлан

2021 онд санхүүгийн дэмжлэгийн арга хэмжээнд 12,913.27 сая төгрөг зарцуулснаас Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөрт 7.2 тэрбум төгрөг буюу 56%, Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 440 сая төгрөг буюу 3%, ХБИ-ний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 4.3 тэрбум төгрөг буюу 34%, Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 897 сая төгрөг буюу 7% тус тус зарцуулагдсан байна.


Санхүүгийн дэмжлэг нь бусад арга хэмжээнүүдтэй харьцуулахад хамгийн өндөр гүйцэтгэлтэй хэрэгждэг арга хэмжээ байна. /Зураг 27, 28/

ЗУРАГ 27. Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээний гүйцэтгэл /хүний тоогоор/



Эх сурвалж: ХНХЯ-ны ХЭБХЗГ-ын мэдээ, тайлан

ЗУРАГ 28. Санхүүгийн дэмжлэгийн санхүүжилтийн гүйцэтгэл /мян.төг/



Эх сурвалж: ХНХЯ-ны ХЭБХЗГазрын мэдээ, тайлан

2017-2021 оны хооронд санхүүгийн дэмжлэгийн хамрах хүрээний төлөвлөгөөний биелэлтийн дундаж гүйцэтгэл 94.68%, санхүүжилтийн 5 жилийн дундаж гүйцэтгэл 84.3% байна.

Санхүүгийн дэмжлэг нь ХЭД сангийн төсвийн хуваарилалтын 60%-75%-ийг эзэлдэг бөгөөд нийт ХЭД хөтөлбөрт хамрагдах зорилтот бүлэг болох байгууллага, аж ахуйн нэгж болон иргэдийн 10%-16%-ийг эзэлж байна.

Санхүүгийн дэмжлэг нь ХХҮГ/Х-ээр үйлчлүүлэгчдийн хамгийн өндөр эрэлт хэрэгцээтэй арга хэмжээ болдог. Санхүүгийн дэмжлэг нь эргэн төлөлттэй болсноор авлага үүссэн, төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтнүүдийн ачааллыг нэмэгдүүлжээ.

Санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээний зохион байгуулалт, журмыг боловсронгуй болгох, хэрэгжүүлэх хүний нөөцийн асуудлыг шийдэх эсхүл санхүүгийн цахим байгууллагууд,

ББСБ зэрэг мэргэжлийн санхүүгийн байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

ШИГТГЭЭ 3.

Орхон, Өвөрхангай аймгийн ХХҮГ-ын мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагаас:

Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт дээр маш их асуудал гарч байна. Төсөл, хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн өр төлбөр цуглуулах, хөөцөлдөх, шүүхэд очих зэрэгт анхаараад үндсэн чиг үүргээ гүйцэтгэхэд хүндрэлтэй болсон. Санхүүгийн дэмжлэг авсан ахмад настан нас барах, ХБИ хэвтэрт орох зэргээс болоод эргэн төлөлтөө хийж чадахгүй болоход шүүхээр орж байж төлбөрөөс чөлөөлдөг боловч програм дээр авлагатай гэж харагдаад байдаг.

Санхүүгийн дэмжлэг эргэн төлөлтгүй байснаа эргэн төлөлттэй болсон, зарим жил эргэн төлөлтийг 50 хувь бууруулдаг, энэ мэт шийдвэрээс болоод иргэд эргэн төлөлтийн хувийг бууруулж магадгүй гэсэн хүлээлт үүсгээд байдаг.

Санхүүгийн дэмжлэгийн арга хэмжээнд хамрагдаж байгаа зорилтот бүлэг нь хувиараа бизнес эрхлэгч, малчин, залуучууд, ахмад настан, ХБИ-тэй өрхийн үйлдвэрлэгч гэх мэт албан бус секторт үйл ажиллагаа явуулж байгаа иргэдийг дэмжиж байгаа учир албан статистик, ажилгүйдлийн түвшин өөрчлөх хэмжээний үр дүнд хүрэхгүй байна. Санхүүгийн дэмжлэгийг олгохдоо шинээр ажлын байр нэмэгдүүлэх, албан бусаас албан секторт шилжих шаардлага тавих нь зүйтэй байна. Тухайлбал, албан секторт шилжээд 3 жил тогтвортой үйл ажиллагаа явуулж, шинээр ажлын байр нэмэгдүүлэн НДШ тогтмол төлбөл эргэн төлөлтгүй болгох г.м хөшүүрэг бий болгож болно.

Санхүүгийн дэмжлэг нь хөтөлбөрүүдэд давтамж өндөртэй тусгагдаж үйл ажиллагааны ихэнх хувийг эзэлж байгаа тул байнгын арга хэмжээ болгох саналтай.

4) Залуучуудын гарааны бизнесийг дэмжих арга хэмжээ

Залуучуудын гарааны бизнесийг дэмжих арга хэмжээ нь “Ажлын гараа”, “Сумын залуус” нэртэйгээр туршилтын төсөл хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2014 оноос Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр болж, одоо шилдэг “Старт-Ап” залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох хэлбэрээр тогтмол хэрэгжүүлж байна.


Аль ч улсад гарааны бизнес эхлүүлэхэд тулгардаг гол асуудал нь санхүүжилт байдаг. Зарим улс орнууд стратегийн ач холбогдолтой гарааны бизнесийг оюуны өмчөөр баталгаажуулан патентжуулах, Засгийн газраас нь буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл олгох зэрэг уламжлалт санхүүжилтийн механизмуудыг ашиглан хувиараа хөдөлмөр эрхлэгч болон гарааны бизнесүүдийг дэмжиж ирсэн. Олон улсад гарааны бизнесийн санаа нь голчлон аливаа салбарын уламжлалт аргыг технологийн дэвшил, хиймэл оюун ухаан, интернэт сүлжээ ашиглан эхлүүлэх чиг хандлагатай байна.

Манай улс гарааны бизнесийн үйл ажиллагааг дэмжих хандлага хөрөнгө оруулагч болон томоохон аж ахуйн нэгжүүдэд бий болсон нь сайшаалтай. Монгол улс Гарааны бизнесийн экосистемийн үнэлгээгээр 2020 онд 93-р байранд байсан бол 2021 онд 5 байраар урагшилж 88-р байранд жагссан эерэг үзүүлэлттэй байна. /Хүснэгт 8, Зураг 29/

ХҮСНЭГТ 8. Гарааны бизнесийн экосистемийн индекс 2021: Топ 10 улс ба Монгол улс

№	Улс	Тоо хэмжээний үнэлгээ	Чанарын үнэлгээ	Бизнесийн хүрээлэн буй орчны үнэлгээ	Нийт оноо
1	АНУ	19.45	101.17	3.80	124.42
2	Их Британи	8.16	16.86	3.70	28.72
3	Израил	5.48	19.14	3.13	27.75
4	Канад	6.58	9.75	3.55	19.88
5	Герман	3.64	9.92	3.49	17.05
6	Швед	2.40	9.24	3.78	15.42
7	Хятад	1.33	11.46	2.34	15.13
8	Швейцар	3.82	7.58	3.54	14.94
9	Австрали	4.46	5.87	3.50	13.83
10	Сингапур	3.22	7.69	2.84	13.75
88	МОНГОЛ	0.10	0.05	0.16	0.314

ЗУРАГ 29. Гарааны бизнесийн экосистемийн индекс 2021



Эх сурвалж: StartupBlink, <https://www.startupblink.com/startupecosystemreport.pdf>
Монголын Энтрепренеруудын нэгдсэн чуулган 2021

Залуучуудын гарааны бизнесийг дэмжих арга хэмжээнд 15-34 насны залуучууд хамрагдах бөгөөд уралдаан хэлбэрээр зохион байгуулагдаж, шалгарсан оролцогчид 10 сая төгрөгийн санхүүжилт олгодог арга хэмжээ юм. Аймагт 1, дүүргүүдэд 2 старт-ап шалгаруулж тус бүр 10 сая төгрөг, улсын хэмжээнд шилдэг 3 старт-ап шалгаруулж 20.0 сая, 17.0 сая, 13.0 сая төгрөгийн эргэн төлөх нөхцөлгүй санхүүгийн дэмжлэг олгож байна.

Залуучуудын гарааны бизнесийг дэмжих арга хэмжээ нь хэрэгжүүлж байгаа аргачлалын хувьд үр дүнтэй, залуучуудыг идэвхжүүлсэн, бизнесийн талаар мэдлэг, ур чадвар олгосон арга хэмжээ болдог боловч санхүүжилтийн хэмжээ нь бага бизнесийг бодитоор дэмжихэд хангалттай хүрэлцдэггүй, зөвхөн нэг л гарааны бизнест олгогддог учраас хүртээмж багатай байна.


Гарааны бизнесийг дэмжих арга хэмжээ нь тухайн цаг үетэй холбоотойгоор хэрэгжүүлэх арга зам өөр, хамрах хүрээ, зохион байгуулалт нь өөрчлөгддөг тул оролцогчдын тоо жил бүр харилцан адилгүй байна. Гарааны бизнесийг дэмжих арга хэмжээний гүйцэтгэлийг Хүснэгт 9, зураг 30-р харуулав.

ХҮСНЭГТ 9. Залуучуудын гарааны бизнесийг дэмжих арга хэмжээний гүйцэтгэл /хүний тоогоор/

Арга хэмжээ	2017	2018	2019	2020	2021
Гарааны бизнес эрхлэхийг дэмжих	31	1,981	3,656	1,093	608

Эх сурвалж: ХНХЯ-ны ХЭБХЗГ-ын мэдээ, тайлан

ЗУРАГ 30. Гарааны бизнесийг дэмжих арга хэмжээний гүйцэтгэл /мян.төг/



Эх сурвалж: ХНХЯ-ны ХЭБХЗГ-ын мэдээ, тайлан

Гарааны бизнесийг дэмжих арга хэмжээнд 15-34 насны залуучууд оролцох боломжтой бөгөөд манай улсын хүн амын бүтцийг аваад үзвэл хүн амын 29.8% нь буюу 1,016.7 мян залуучууд байна. Энэ арга хэмжээнд нийт ХЭД сангийн төсвийн ердөө 0.8-3.9%-ийг зарцуулдаг ба залуучуудад үр өгөөжтэй, хүсэн хүлээдэг арга хэмжээ болсон байна.

Цаашид хөтөлбөрт хамрагдсан гарааны бизнесийг эхлүүлсэн залуучуудад албан бизнес эрхлэх сонирхлыг бий болгохуйц агуулгатай болгон өөрчилж, хөтөлбөрийг шинэчлэн хөдөлмөр эрхлэлтийн шинэ төрөл хэлбэрийг дэмжихүйц хөтөлбөр хэлбэрээр нь үргэлжлүүлэх саналтай байна.

5) Ажилд зуучлах үйлчилгээ

Ажилд зуучлах үйлчилгээ нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нийтлэг үйлчилгээнээс гадна ХЭД хөтөлбөрүүдэд давхар тусгагдаж 10 жилийн туршид 7 хөтөлбөрөөр хэрэгжсэн. Үүнд:


- 1) Оюутны хөдөлмөр эрхлэлт ба цагийн ажил;
- 2) Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх;
- 3) Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, ажлын байр хадгалах;
- 4) Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;

- 5) Ажлын байрыг дэмжих;
- 6) Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр;
- 7) ХБИ-ий ажлын байрыг дэмжих хөтөлбөр.


ХЭД хөтөлбөрийн үр дүн нь ажлын байр хэрхэн нэмэгдсэнээр үнэлэгдэж байгаа боловч энэ үйлчилгээнд маш бага төсөв хуваарилагддаг. Мөн ХЭД хөтөлбөрт хамрагдан зуучлагдсан хүн давхар нийтлэг үйлчилгээнд бүртгэгдэх тохиолдол ч байдаг.

ХЭД хөтөлбөрт тусгагдсан ажилд зуучлах үйлчилгээний гүйцэтгэлийг зураг 31, 32-т харуулав.

ЗУРАГ 31. Ажилд зуучлах үйлчилгээ/ хүний тоогоор/



ЗУРАГ 32. Ажилд зуучлах үйлчилгээ /мян.төг/



Эх сурвалж: ХНХЯ-ны ХЭБХЗГ-ын мэдээ, тайлан

2017-2021 онд ХЭД хөтөлбөрийн ажилд зуучлах үйлчилгээнд нийт 44,508 хүн хамрагдсан бөгөөд 349,430 мянган төгрөг зарцуулсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын эцсийн үр дүн нь ажлын байр бий болгох, ажилгүйдлийг бууруулах, ажилгүй иргэнийг ажилд зуучлан ажилтай орлоготой болгосноор хэмжигдэж байгаа боловч энэ арга хэмжээнд ХЭДС-ийн нийт төсвийн ердөө 0.2-0.4%-ийг зарцуулдаг.


Хөтөлбөрөөр хэрэгжиж байгаа ажил зуучлалын үйлчилгээнд хамрагдсан иргэн нийтлэг үйлчилгээний ажил зуучлалд давхар бүртгэгдэх боломжтой байна. Тиймээс ажил зуучлалыг зөвхөн нийтлэг үйлчилгээний хүрээнд зохион байгуулах боломжтой гэж үзэж байна.

6) Бусад арга хэмжээ

Бусад арга хэмжээнд ажилд зуучлах уулзалтад бэлтгэх, хоол унааны зардал өгөх, хүүхэд хамгаалах үйлчилгээг зохион байгуулах, хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэх гэх мэт тухайн онд нэг удаа хэрэгжээд больсон өмнөх арга хэмжээний төрөлд багтаагүй арга хэмжээнүүдийг энэхүү бусад арга хэмжээнд хамааруулж авч үзэв. 2021 онд ЗГ-аас хэрэгжүүлсэн оролцоо төслийг энэхүү арга хэмжээнд оруулсан учраас эзлэх хувь өссөн үзүүлэлтэй гарсан.

ХЭД хөтөлбөрийн хэрэгжилтийн хувьд өөр өөр нэрээр зорилтот бүлгээрээ ялгаатай олон хөтөлбөрийг хэрэгжүүлсэн ч арга хэмжээний хувьд давхцал ихтэй хэрэгжиж байжээ. 2017-2021 онд хэрэгжсэн ХЭД хөтөлбөрүүдийг ерөнхий 6 арга хэмжээний төрөлд ангилан арга хэмжээ тус бүрт хамрагдсан хүний тооны эзлэх хувийг зураг 33-аар харуулав.

ЗУРАГ 33. Тухайн арга хэмжээнд хамрагдсан хүний тоо, эзлэх хувиар



Эх сурвалж: ХНХЯ, 2021

Тухайн арга хэмжээнд хамрагдсан хүний тоог ХЭД хөтөлбөрт хамрагдсан нийт хүний тоонд харьцуулбал, санхүүгийн дэмжлэгт 9.6-16.6%, сургалтад 30.1-44.9%, нийтийг хамарсан ажилд 30.7-42.8%, ажилд зуучлах үйлчилгээнд 4.2-25.4%, гарааны бизнесийг дэмжих арга хэмжээнд 0.1-4.9%, бусад арга хэмжээнд 2.1-2.4% нь тус тус хамрагдсан байна.

Санхүүгийн дэмжлэг, нийтийг хамарсан ажил, сургалтын арга хэмжээ нь жил бүр тасралтгүй хэрэгжиж иржээ. **2017-2021 оны 5 жилийн дунджаар харвал, ХЭД хөтөлбөрт хамрагдсан нийт хүний 80.2% нь зөвхөн эдгээр 3 арга хэмжээнд хамрагдаж, хөтөлбөрийн нийт санхүүжилтийн 94.9% нь эдгээр 3 арга хэмжээнд зарцуулагдсан байна. Тиймээс энэ 3 арга хэмжээг хөтөлбөрөөс салгаж байнга хэрэгжих арга хэмжээ байдлаар төлөвлөж, хэрэгжүүлэх нь зүйтэй байна.**

Түүнчлэн ХЭД хөтөлбөрт арга хэмжээ болж ордог ажилд зуучлах үйлчилгээг хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хүрээнд зохион байгуулах, гарааны бизнесийг дэмжих болон

бусад онцлог арга хэмжээг хөтөлбөр хэлбэрээр үргэлжлүүлэх саналтай байна. Өөрөөр хэлбэл, ХЭД хөтөлбөрийн тоог цөөлж байнгын хэрэгждэг арга хэмжээг хөтөлбөрөөс салгаж төлөвлөн, жилд тухайн үеийн нөхцөл байдал, орон нутгийн онцлог, ЗГ-ын бодлого, шийдвэртэй уялдсан 2-3 хөтөлбөрийг хэрэгжүүлж, хөтөлбөр, арга хэмжээг хослуулан уян хатан төсвийн төлөвлөлт хийдэг болох шаардлагатай байна.

Жил бүр дунджаар 5-7 ХЭД хөтөлбөр баталж, хэрэгжүүлдэг боловч хөтөлбөрийн хамрах хүрээ хэт хязгаарлагдмал, арга хэмжээнүүд нь ижил төстэй, хөтөлбөрийн төсвийн 80 гаруй хувь нь зөвхөн 3 арга хэмжээнд хуваарилагддаг учраас бусад олон жижиг арга хэмжээг үр дүнтэй байсан эсэхэд дүгнэлт хийх нь учир дутагдалтай юм. Жил бүр ХЭД хөтөлбөр хэрэгжүүлдэг боловч хөтөлбөрт хамрагдсан иргэдээс ажлын байртай болсон иргэдийн хувь сүүлийн 5 жилийн дунджаар дөнгөж 16.18% байна. Тиймээс **ХЭД хөтөлбөрийн үр дүнг хангалтгүй буюу эрчимжүүлэх шаардлагатай** гэж үнэлэв.

3.3. ХЭД ХӨТӨЛБӨР, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙН ҮР АШИГ

2012-2021 оны 10 жилийн хугацаанд төрөөс үзүүлэх хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөтөлбөр, арга хэмжээнд 1,587,179 хүнийг хамруулж, ХЭДС-аас 271.5 тэрбум төгрөгийг зарцуулжээ. Үүнээс хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд давхардсан тоогоор 1,107,186 хүнийг хамруулж, 9.2 тэрбум төгрөгийг зарцуулсан бол ХЭД хөтөлбөр, арга хэмжээнд 479,993 хүнийг хамруулж 262.3 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. /Хүснэгт 10/

ХҮСНЭГТ 10. ХЭД хөтөлбөр, үйлчилгээнд зарцуулсан хөрөнгө

ОН	Төсөв /тб.төг/			Хамрагдсан хүний тоо			Нэг хүнд ноогдсон зардлын хэмжээ /мян.төг/		
	НҮ	ХЭДХ	НИЙТ	НҮ	ХЭДХ	НИЙТ	НҮ	ХЭДХ	НИЙТ
2012	0.9	15.5	16.4	-	-	-	-	-	-
2013	1.2	46.8	47.9	196,824	118,920	315,744	5.8	393.5	151.9
2014	1.1	37.6	38.7	135,592	51,314	186,906	8.1	733.7	207.3
2015	0.5	28.9	29.4	63,781	38,518	102,299	7.1	751.4	287.4
2016	1	17.8	18.7	64,680	41,827	106,507	15	424.9	176
2017	0.8	23.5	24.3	149,545	48,286	197,831	5.4	487.4	123.1
2018	1	25.4	26.4	133,066	59,963	193,029	7.6	423.5	136.8
2019	1.3	30.2	31.5	162,643	74,487	237,130	8.2	404.8	132.8
2020	0.7	17.8	18.4	84,573	28,632	113,205	8	620.3	162.8
2021	0.8	18.8	19.6	116,482	18,046	134,528	6.9	1,041.80	145.8
НИЙТ	9.2	262.3	271.5	1,107,186	479,993	1,587,179	8.3	546.5	171.1

Эх сурвалж: ХНХЯ-ны мэдээлэлд үндэслэж төслийн зөвлөх тооцоолов.

9 жилийн дунджаар тооцоход нийтлэг үйлчилгээнд хамрагдсан хүний тоо хөтөлбөрт хамрагдсан хүний тооноос 2.3 дахин их байна. Нэг хүнд ногдсон зардлыг харьцуулахад нийтлэг үйлчилгээ авах нэг хүнд ногдох зардал нь хөтөлбөрт хамрагдсан нэг хүнд ногдох зардлаас 73.2 дахин бага байна.


Өнгөрсөн 9 жилд 1.1 сая хүнд үйлчилгээ үзүүлж, 1 хүнд 8.3 мянган төгрөг зарцуулсан бол ХЭД хөтөлбөрт 480 мянган хүнийг хамруулж, 1 хүнд 546 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, ХЭД хөтөлбөрт өнгөрсөн 10 жилийн хугацаанд нийтдээ 271.5 тэрбум төгрөг зарцуулсан нь нийгмийн халамжийн 1-2 тэтгэмжийн зөвхөн жилийн зардалтай ойролцоо байна. ХЭД хөтөлбөр, арга хэмжээ, үйлчилгээнд аль болох олон хүнийг бага зардлаар хамруулж, иргэдэд ур чадвар олгох, ажилтай, орлоготой болгохыг зорьжээ. Иймд ХЭДС-аас хөтөлбөр, үйлчилгээнд зарцуулж буй хөрөнгийг үр ашигтай байсан гэж үнэлэв.

3.4. ХЭД ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨЛТ БА ГҮЙЦЭТГЭЛ

ХЭД хөтөлбөрийн төлөвлөлт ба гүйцэтгэл ХЭД хөтөлбөрүүдийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээг нийтлэг шинж чанараар нь 6 бүлэгт хуваасан ба бүлэг арга хэмжээ тус бүрийн санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийг сүүлийн 5 жилээр харуулав. /Зураг 34/

ЗУРАГ 34. ХЭД хөтөлбөрийн арга хэмжээ төсвийн зарцуулалт, хувиар



Дээрх зураг 34-өөс харахад 2017-2021 онд хэрэгжсэн ХЭД хөтөлбөрийн арга хэмжээний төсвийн зарцуулалт 31-95% гүйцэтгэлтэй, үүнээс санхүүгийн дэмжлэг нь 77-92%, сургалт 63%-86%, нийтийг хамарсан ажил 85-92%, ажилд зуучлах үйлчилгээ 31-72%, гарааны бизнесийг дэмжих 62-95%, бусад арга хэмжээ 59-70% тус тус гүйцэтгэлтэй байна.

Сүүлийн 5 жилийн дунджаар хуваарилсан төсвийн зарцуулалтын хамгийн бага гүйцэтгэлтэй нь ажилд зуучлах үйлчилгээ 56%, хамгийн өндөр гүйцэтгэлтэй нь нь нийтийг хамарсан ажил 88%-тай байна. ХЭД хөтөлбөрт төсөвлөсөн хөрөнгийн зарцуулалтын гүйцэтгэл 2017 онд 68.5%, 2018 онд 77.6%, 2019 онд 80%, 2020 онд 74.1%, 2021 онд 77.9% байгаа нь шаардлагатайгаас илүү хөрөнгө төсөвлөдөг эсхүл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй, хөтөлбөрийн арга хэмжээ оновчтой бус гэсэн шалтгаануудтай байж болно.

ШИГТГЭЭ 3.

Орхон, Өвөрхангай аймгийн ХХҮГ-ын мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагаас:

Зарцуулаагүй зардлыг хэрэгцээт аймаг, дүүрэгт шилжүүлэн хуваарилдаг байх.

Тухайн жилийн санхүүжилтийг бүрэн зарцуулахгүй бол ирэх жил төсвийг хасна гэж дээрээс шахдаг, тухайн жил тэр бүс нутагт үүссэн цаг агаарын болон бусад нөхцөл байдлыг харгалздаггүй.

Ажлын байрны дэмжлэгийн санхүүжилтийн хэмжээ бага учраас шинээр ажлын байр бий болгох тохиолдолд л олгодог. Борлуулалтын дэмжлэг арга хэмжээ хэрэгждэггүй. Учир нь борлуулалтын нэгдсэн цэг байх ёстой бөгөөд одоогоор байхгүй. Үзэсгэлэн, худалдаа зохион байгуулах үед бага хэмжээгээр зардал гаргадаг.

Үйлдвэрлэл дээрх сургалт явуулах ажил олгогчид тавих шаардлага нь өндөр учраас ажил олгогчид сонирхохгүй байна. Тухайлбал, анги дүүргэлт 10-15 хүнийг хамруулах, нийгмийн даатгалын шимтгэл төлөх, ажлын байраар хангах ёстой гэсэн шалгуур өндөр байна.

2021 онд ХЭД хөтөлбөрийн төсвийн зарцуулалтын сарын гүйцэтгэлд үнэлгээ хийж үзэхэд оны төгсгөлд төсөвт хуваарилагдсан санхүүжилтийнхээ дийлэнхийг зарцуулдаг байна. /Хүснэгт 11/


ХҮСНЭГТ 11. ХЭД хөтөлбөрийн төсвийн 2021 оны 10 ба 12 дугаар сарын гүйцэтгэл

ХЭД хөтөлбөрүүд	Батлагдсан төсөв (сая төг)	Гүйцэтгэл (сая төг)	Гүйцэтгэл 10 дугаар сарын байдлаар	Гүйцэтгэл 12 дугаар сарын байдлаар	10 ба 12 дугаар сарын зөрүү %
1	2	3	4	5	5-4
Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр	988.0	497.9	29.13%	50.4%	21.26%
Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр	11,433.2	9,880.2	60.11%	86.42%	26.31%
Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	880.1	772.9	50.39%	87.82%	37.43%
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	8,377,3	6,432,8	38.51%	76.79%	38.28%
Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	1,404.0	1,216.7	77.84%	86.66%	8.81%

Эх сурвалж: ХНХЯ, 2021

ХЭД хөтөлбөрийн төсвийн гүйцэтгэлийг 2021 оны 10 дугаар сар болон 12 дугаар сарын байдлаар авч үзэхэд Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрийн төсвийн зарцуулалт 50.4%-ийн гүйцэтгэлтэй, үүнээс төсвийн 29.13%-ийг эхний 10 сард зарцуулж 21.26%-ийг оны сүүлийн 2 сарын хугацаанд зарцуулсан байна. Зарцуулалтын хамгийн өндөр гүйцэтгэлтэй буюу төсвийнхөө 87.82%-ийг зарцуулсан Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн төсвийн 50.39%-ийг нь эхний 10 сард, 37.43%-ийг сүүлийн 2 сард тус тус зарцуулсан байна. /Зураг 35/

ЗУРАГ 35. Хөтөлбөрийн төсвийн зарцуулалт, хувиар



Эх сурвалж: ХНХЯ-ны ХЭБХЗГ-ын мэдээ, тайлан

ХБИ-ий ХЭД хөтөлбөрийн төсвийн зарцуулалт 2021 онд 76.79%-ийн гүйцэтгэлтэй байсан бөгөөд 2021 оны эхний 10 сард үүний 50%-ийг гүйцэтгэсэн бол сүүлийн 2 сарын хугацаанд 50%-ийг зарцуулсан байна. ХЭД хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлдэг ХХҮЕГ, НХЭГ, аймаг, дүүргийн ХХҮГЛХ-үүд хуваарилагдсан төсвөө бүрэн зарцуулахын тулд оны эцэст ачаалалтай ажилладаг болох нь харагдаж байна.

ХЭД хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулахаар төсөвлөсөн хөрөнгийн зарцуулалтын гүйцэтгэл доогуур байхад хэд хэдэн хүчин зүйл нөлөөлж байна. Үүнд:

- ХЭДС-ийн орлогын гол эх үүсвэр болох гадаад иргэдийн ажлын байрны төлбөрийн орлогын бүрдүүлэлт жилийн зарим саруудад илүү төвлөрдөг учраас хөтөлбөр, арга хэмжээг жилийн турш хэрэгжүүлж, жигд зарцуулалт хийх боломжгүй байна;
- ХЭДС-ийн өмнөх оны үлдэгдлийг санд шилжүүлэх санхүүжилтийн эрх нээгдэхгүй уддаг (ихэвчлэн 3-4 дүгээр сард санхүүжилт хийгддэг) учраас эхний улиралд орлогогүйн улмаас ХЭД хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлдэггүй;
- ХЭДС-аас санхүүжүүлэх ХЭД хөтөлбөрийг жил бүр (зарим үед 2 жилд 1 удаа) ХЭҮЗ-өөс шинэчлэн баталдаг. Хөтөлбөрийг ихэвчлэн он гарсны дараа баталдаг бөгөөд түүний дараа хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсвийн хуваарийг батлах учраас жилийн эхний саруудад хөтөлбөрүүдэд төсөв зарцуулагддаггүй;
- Тухайн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зарим хөтөлбөрүүдийг дагаж гарах журам, заавар батлагдахгүй удах зэргээс шалтгаалж хөтөлбөрийн хэрэгжиж эхлэх хугацаа хойшлох тохиолдол гардаг;
- Зарим шинэ хөтөлбөр, арга хэмжээ нь тухайн орон нутгийн онцлог хэрэгцээ, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцэхгүй байх эсхүл хөтөлбөрийн талаар хангалттай мэдээлэл түгээгээгүйгээс хөтөлбөрт иргэн хамрагдахгүй байх. Тухайлбал, 2020 онд НХЭГ-т ХЭДС-аас хуваарилагдсан төсвийн 47.8 хувь нь Гэрээт малчин хөтөлбөрт тавигдсан боловч хөтөлбөрт хамрагдах хүн цөөн байснаас зарцуулалтын

гүйцэтгэл бага хувьтай гарсан. Хэдийгээр ХЭҮЗ-ийн хурлаар төсвийг өөр хөтөлбөрт шилжүүлж болох байсан ч цаг хугацааны хувьд өөр арга хэмжээ хэрэгжүүлэх боломжгүй болсон учраас тухайн жилийн гүйцэтгэл доогуур гарсан нь мөн дараа оны төлөвлөлтөд нөлөөлжээ.

- ◆ Хөтөлбөрийн дизайн орон нутгийн онцлогт нийцдэггүй, зарим хөтөлбөрийг олон жил хэрэгжүүлснээс хамрагдах хүн олдохгүй болсон, хөтөлбөр, арга хэмжээнд хамрагдах хүний тооны квотыг тухайн орон нутгийн саналд үндэслэн хуваарилдаггүй ХХҮЕГ-аас шууд тогтоодог гэх мэт төлөвлөлттэй холбоотой асуудлууд байна.

Цаашид ХЭД хөтөлбөрийн төсвийн гүйцэтгэлийг ондоо багтааж зарцуулж дууссанаар биш, хөтөлбөрийн үр дүнд чанарын үнэлгээ хийж, дараагийн хөтөлбөрөө оновчтой төлөвлөж, боловсруулах шаардлагатай байна. Иймд ХЭД хөтөлбөрийн **төлөвлөлтийн хэрэгжилтийг хангалтгүй** гэж үнэлэв.

Тиймээс ХЭД хөтөлбөрийн төлөвлөлт, төсөвлөлтийг боловсронгуй болгох, **үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийг нэн яаралтай туршиж, хэрэгжүүлэх** зайлшгүй хэрэгцээ шаардлага гарч байна.

3.5. ХЭД ХӨТӨЛБӨРИЙН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ

Өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн ХЭД хөтөлбөрийг ерөнхийд нь өндөр ач холбогдолтой хөтөлбөр боловч хэрэгжилт, үр дүнг эрчимжүүлэх шаардлагатай, хөтөлбөр санхүүжилтийн үр ашигтай, хөтөлбөрийн төлөвлөлтийн хэрэгжилт хангалтгүй гэж үнэлэв. /Хүснэгт 12/.

ХҮСНЭГТ 12. ХЭД хөтөлбөрийн үр дүнгийн үнэлгээ

Үнэлгээний шалгуур	Үнэлгээ	Тайлбар
Ач холбогдол	Өндөр ач холбогдолтой	ХЭД тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж, ХЭД арга хэмжээг хөтөлбөрт суурилсан байдлаар хэрэгжүүлэх болсон нь тухайн үед өндөр ач холбогдолтой байсан. Хөдөлмөрийн зах зээлд шууд нэвтрэхэд хүндрэлтэй ХБИ, ахмад настан, залуучууд, удаан хугацаагаар ажилгүй байгаа иргэн, зэрэг хүн амын зорилтот бүлэгт чиглэсэн хөтөлбөрүүд хэрэгжих болсон. Хөтөлбөрийн арга хэмжээг өөрчлөхөд уян хатан байх нөхцөл бүрдсэн.
Үр дүн	Эрчимжүүлэх шаардлагатай	Хөтөлбөрийн үр дүн хангалтгүй эрчимжүүлэх шаардлагатай. Үйлчилгээний чанар, өгөөж буурсан. Хөтөлбөрийн хамрах хүрээ хэт хязгаарлагдмал, цөөн арга хэмжээ нь өндөр төсөвтэй. Хөтөлбөрт хамрагдсан иргэдээс ажлын байртай болсон иргэдийн хувь 20%-д хүрэхгүй байна.
Үр ашиг	Үр ашигтай	ХЭДС-аас хөтөлбөр арга хэмжээнд зарцуулж буй хөрөнгө үр ашигтай байсан. Бага зардлаар аль болох олон хүнийг хамруулахыг зорьсон. Өнгөрсөн 9 жилд 1.1 сая хүнд үйлчилгээ үзүүлж, 1 хүнд 8.3 мянган төгрөг зарцуулсан бол хөтөлбөрт 480 мянган хүнийг хамруулж, 1 хүнд 546 мянган төгрөг тус тус зарцуулжээ.
Төлөвлөлт ба гүйцэтгэл	Төлөвлөлтийн хэрэгжилт хангалтгүй	Төсвийн хуваарилалт орон нутгаар төдийгүй хөтөлбөр арга хэмжээгээр оновчтой байгаагүй. Үйлчилгээ, хөтөлбөрт хамруулахаар төлөвлөсөн хүний тоонд хүрч ажиллаагүй. Гүйцэтгэл хангалтгүй. Үйлчилгээ, хөтөлбөрт чанар, үр дүнгийн хяналт тавьдаггүй.

4

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ҮНЭЛГЭЭ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны оролцогчид нь бодлого боловсруулагч ЗГ, ХНХЯ, бусад яамд, бодлогын хэрэгжилтийг зохион байгуулагч ХХҮЕГ болон НХЭГ, аймгийн ХХҮГ, дүүргийн ХХҮХ, бодлого, хэрэгжилтийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэгч ОУ-ын төсөл хөтөлбөр, Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл арга зүйн төв, ХНХСИ, мэргэжлийн холбоод, үйл ажиллагааг гэрээгээр гүйцэтгэгч хөдөлмөрийн биржүүд, сургалтын байгууллага, ажил олгогч, ТББ, ашиг хүртэгч буюу хөтөлбөрт хамрагдах зорилтот бүлгийн иргэд, бизнес эрхлэгч, ажилгүй иргэд юм. /Зураг 36/.

ЗУРАГ 36. Үйлчилгээ үзүүлдэг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд



ХЭД хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч тал болох сургалтын байгууллага, хөдөлмөрийн хувийн бирж, аж ахуй эрхлэх сургалт зохион байгуулагч, бизнесийн зөвлөгөө өгдөг байгууллага болон төрийн байгууллагаас анкетын аргаар судалгааны асуулга боловсруулан

ХЭД хөтөлбөрийг үнэлүүлэв. Энэхүү үнэлгээнд төрийн байгууллагын /ХНХЯ, ХХҮЕГ, НХЭГ, аймаг дүүргийн ХХҮГ/Х, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр ажиллаж байгаа ОУ-ын төсөл/ 110 хүн, хувийн хэвшлийн байгууллагын /хувийн бирж, сургалтын байгууллага/ 55 хүн оролцов. Судалгааны асуулгыг Хавсралт 2, 3-аас харна уу.

2021 онд хэрэгжсэн хөтөлбөрийг оролцогч талуудаар үнэлүүлсэн үнэлгээний үр дүнг хүснэгт 13-т харуулав.

ХҮСНЭГТ 13. 2021 оны ХЭД хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын үнэлгээ

Хөтөлбөрийн нэр	Төрийн байгууллага /110 хүн/		Хувийн байгууллага /55 хүн/	
	Эерэг үнэлгээний индекс /PI/	Ерөнхий үнэлгээ /OI/	Эерэг үнэлгээний индекс /PI/	Ерөнхий үнэлгээ /OI/
1. Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр	24.6	57.7	27.3	60.5
2. Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр	35.3	67.1	23.2	52.7
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	34.8	65.7	25.0	57.7
4. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	32.1	62.3	24.4	56.7
5. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	37.5	66.4	23.7	52.6
Ерөнхий дундаж үнэлгээ	32.9	63.9	24.7	56.0


Энэхүү үнэлгээг Сингапур улсын олон улсын хүний нөөцийн зөвлөх үйлчилгээний Делтрон компанийн боловсруулсан үнэлгээний аргачлалыг үндэслэн хийв. Дээрх хүснэгтэд 2021 онд хэрэгжүүлсэн хөтөлбөр тус бүрийг оролцогч талуудаар 1-5 оноогоор үнэлүүлсэн бөгөөд ерөнхий үнэлгээний индекс / OI- Overall index³ /, хариултад эзлэх эерэг үнэлгээний индекс / PI - Positive index⁴/ -ийг харьцуулан харуулав. Үнэлгээний аргачлалын дагуу 0-100%-аар үнэлж байгаа бөгөөд ерөнхий үнэлгээ нь 25%-аас доош бол маш муу, 26-50% бол муу, 51-75% бол сайн, 76-100% бол маш сайн гэж үнэлдэг.

Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн байгууллагын 110 албан хаагчаас авсан судалгааны дүнгээс харахад 2021 онд хэрэгжүүлсэн ХЭД хөтөлбөрт өгсөн ерөнхий үнэлгээний индекс нь 63.9 байна. Энэ нь дунджаас дээгүүр буюу сайн хэрэгжүүлсэн гэж үнэлсэн байна. Үүнээс эерэг үнэлгээний индекс буюу 4-5 оноо өгсөн хариултын хувь нь нийт хариултын 32.9%-ийг эзэлж байна.

3 $OI = ((N + (NS * 2) + (A * 3) + (Y * 4) + (DY * 5)) / (P * Q * 5)) * 100$
 OI-г гаргахад ((оноо бүрийг тухайн тоогоор нь үржүүлсэн нийлбэр)) хуваах (оролцогчдын тоо * асуултын тоо * 5)) * 100-аар үржүүлнэ.

4 $PI = ((Y + (DY * 2)) / (Q * P * 2)) * 100$
 PI-г гаргахад: ((4 оноогоор үнэлсэн нийт тоог 1-ээр + (5 оноогоор үнэлсэн тоог 2-оор үржүүл) хуваах нь (асуултын тоо * оролцогчдын тоо * 2)) * 100-аар үржүүлнэ.

ЗУРАГ 37. ХЭД хөтөлбөрийн үр дүнд төрийн байгууллагын ажилтнуудын өгсөн үнэлгээ




Төрийн байгууллагын мэргэжилтнүүдийн үнэлгээгээр 2021 онд хэрэгжүүлсэн ХЭД хөтөлбөрүүдээс хамгийн сайн нь “Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр” бөгөөд ерөнхий индекс нь 67.1 байна. Хамгийн бага үнэлгээ авсан нь “Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр” бөгөөд ерөнхий индекс нь 57.7 байна.

Хөдөлмөрийн бирж, сургалтын байгууллага зэрэг хувийн хэвшлийн 55 байгууллагаас авсан үнэлгээгээр 2021 онд хэрэгжүүлсэн ХЭД хөтөлбөрийн ерөнхий үнэлгээний индекс нь 56.0 бөгөөд үүнээс эерэг үнэлгээний индекс нь 24.7 байна.

2021 онд хэрэгжүүлсэн ХЭД хөтөлбөрт өгсөн хувийн байгууллагуудын ерөнхий үнэлгээг зураг 38-с харна уу.

ЗУРАГ 38. ХЭД хөтөлбөрт хувийн байгууллагуудын өгсөн үнэлгээ



Хувийн байгууллагын ажилтнуудын үнэлгээгээр 2021 онд хэрэгжүүлсэн ХЭД хөтөлбөрүүдээс хамгийн сайн нь “Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр” бөгөөд ерөнхий индекс нь 60.5 байна. Хамгийн бага үнэлгээ авсан нь “Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” бөгөөд ерөнхий индекс нь 52.6 байна.

Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрийг төрийн байгууллагын мэргэжилтнүүд хамгийн муу хэрэгжүүлсэн гэж үнэлсэн байхад хувийн байгууллагын ажилтнууд бусад хөтөлбөрүүдээс илүү сайн хэрэгжүүлсэн гэж үнэлсэн байна. Энэ нь Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрийн сургалтын арга хэмжээг хувийн хэвшлийн сургалтын байгууллагууд гэрээгээр гүйцэтгэж, хэрэгжүүлдэгтэй холбоотой байж болно.

Хэдийгээр хувийн хэвшлийнхэн ХЭД хөтөлбөрийн хэрэгжилтийг дунджаас дээгүүр сайн гэж үнэлсэн боловч төрийн байгууллагын мэргэжилтнүүдийн үнэлгээнээс 7.9 пунктээр доогуур, эерэг үнэлгээний индекс нь 8.2 пунктээр тус тус доогуур үнэлсэн байна.

Нээлттэй асуулгаар ХЭД хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд давуу болон сул тал нь юу байсныг тодруулсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд оролцогч хувийн хэвшлийн сургалтын байгууллага, хөдөлмөрийн биржүүд, аж ахуй эрхлэлтийн сургалт, стартап хөтөлбөрийг хэрэгжүүлдэг Монголын бизнес инкубаторын үндэсний нэгдсэн холбооны гишүүн байгууллагуудын төлөөлөл ХЭД хөтөлбөрүүдийг дараах давуу талтай байсан гэж үзсэн. Үүнд:

- ◆ Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөр маш шинэлэг хүртээмжтэй;
- ◆ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүрч чадсан;
- ◆ Хөдөлмөрт бэлтгэх сургалт иргэдийг нийгэмшүүлж, төлөвшүүлдэг;
- ◆ Хүмүүсийг идэвхжүүлж мэдлэг мэдээлэл өгөхөд эергээр оролцдог;
- ◆ Иргэдэд цаг үеэ олсон дэмжлэг болсон, сургалтаар иргэд мэдлэг олж авч үйл ажиллагаагаа төлөвлөгөөтэй, дэс дараатай, эмх цэгцтэйгээр эрхлэн хөтөлж байна;
- ◆ Олон иргэдийн хүсэл сонирхолд нийцүүлэн сургалтуудыг явуулж ирсэн;
- ◆ ХЭД хөтөлбөрт иргэд хамрагдсанаар мэдлэгээ дээшлүүлэх, ХЗЗ-ийн талаар мэдлэгтэй болох ажлын байртай болох арга замаа тодорхойлох, хөдөлмөрийн харилцаанд орох боломжтой болдог;
- ◆ Ажилгүйдэл, ядуурал, шилжин суурьшигч ихтэй энэ хэцүү цаг үед иргэдийг сургалтад хамруулж ур чадвар олгож ажлын байранд зуучлах нь МАШ ЧУХАЛ АСУУДАЛ;
- ◆ Хөдөлмөрт бэлтгэх сургалтыг мэргэжлийн сургалттай хослуулах боломжтой.

Хувийн хэвшлийн байгууллагуудын төлөөлөл ХЭД хөтөлбөрүүд дараах сул талтай байсан гэж үзсэн. Үүнд:

- ◆ Тухайн иргэний сургалтын хэрэгцээг тодорхойлохгүйгээр шууд сургалтад оролцуулдаг нь үр дүнд муугаар нөлөөлдөг;
- ◆ Санхүүжилт хүрэлцдэггүй;
- ◆ ХБИ-ий болон Ахмад настны ХЭД хөтөлбөр хүртээмжгүй, оновчгүй, хүнд суртал ихтэй, хээл хахууль авдаг;
- ◆ Хөтөлбөрүүдийн хүрээнд хөдөлмөрийн харилцаа, эрх зүйн зохицуулалт, ажлын ярилцлага, CV бичих талаар дэлгэрэнгүй мэдээлэл авч чаддаггүй;
- ◆ Хөтөлбөрт хамрагдаж байгаа иргэдийн идэвх оролцоо сул;

- ◆ Төрийн байгууллагын хүнд суртал их, тооны хойноос хэт их анхаардаг;
- ◆ ХЭД хөтөлбөрийн талаарх мэдээлэл бага, иргэд хөтөлбөрт хамрагдахын тулд танил тал хайх, хамрагдаж чадахгүй байх явдал их;
- ◆ Санхүүгийн дэмжлэгийн хэмжээ бизнесийн үйл ажиллагааны эргэлтэд дэмжлэг болохоор хүрэлцээтэй биш;
- ◆ ХБИ-ий сургалтад санхүүжилтийг нэмж тусгах шаардлагатай. Тусгай ур чадвартай багш нар хичээл заадаг учраас төлбөр нь өндөр байдаг;
- ◆ Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлөөс бизнесийн чиглэл зааж, ахуйн үйлчилгээ, үйлчилгээний бизнесийг орхигдуулсан нь үйлчилгээний төрлийн бизнес эрхлэгчдэд боломжийг хаасан зүйл болсон;
- ◆ ХЭДС-аас олгох санхүүжилт цаг хугацаандаа орж ирдэггүй;
- ◆ ХЭД хөтөлбөрийн хүртээмж муу, яг эзэндээ хүрдэггүй;
- ◆ Мэргэжлийн сургалтын төлбөр маш бага, тариф өөрчлөгдөөгүй нэг хөтөлбөрөөр маш олон жил явуулж байгаа нь чанарт нөлөөлж байна.
- ◆ Орон нутагт сургалтын зардлыг нэг цагийн үнэлгээгээр санхүүжүүлэх ёстой, түүнчлэн багшийн томилолтын зардлыг шийдэх, сургалтын анги танхим түрээслэх зардал тусгах, эсвэл ХХҮГХ-үүд өөрсдөө хариуцдаг байх;
- ◆ Хөдөлмөрт бэлтгэх бүлгийн сургалтыг хийхэд иргэдийн оролцоог жигд, тогтвортой хангахад хүндрэлтэй;
- ◆ Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ байнгын хэрэгждэг боловч хувийн биржүүдэд олгодог санхүүжилт тасалддаг;
- ◆ ХЭД хөтөлбөрийн хэрэгжих хугацаа богино, үр дүнгийн хяналт сул, санхүүжилтийн хэмжээ бага, хөтөлбөр хооронд төсвийн шилжүүлэлт уян хатан бус, төсөв, квот орон нутгийн онцлогтой уялддаггүй, хамрах хүрээний судалгаа байхгүй байна.

5

ДҮГНЭЛТ, САНАЛ

УИХ-аас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2012 онд баталснаас хойш өнгөрсөн 10 жилийн хугацаанд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг хөтөлбөр байдлаар төлөвлөж, хэрэгжүүлсэн. Энэ хугацаанд ХЭД хөтөлбөрүүдэд цогц байдлаар үнэлгээ хийгээгүй, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг ихэвчлэн тухайн жилийн төсвийн гүйцэтгэлд үндэслэн дүгнэж ирсэн дутагдалтай байна. Энэхүү тайланд ХЭД хөтөлбөрийг арга хэмжээгээр нь задлан шинжилж, төстэй арга хэмжээнүүдийг бүлэглэх замаар ХЭД хөтөлбөрийн үндсэн арга хэмжээнүүдийг тодорхойлов. Эдгээр үндсэн арга хэмжээ тус бүрийн хэрэгжилтийг үнэлэхийг оролдсон болно.

ХЭД арга хэмжээг хөтөлбөрт суурилсан байдлаар хэрэгжүүлэх болсон нь тухайн үед өндөр ач холбогдолтой байсан. Хөдөлмөрийн зах зээлд шууд нэвтрэхэд хүндрэлтэй ХБИ, ахмад настан, залуучууд, удаан хугацаагаар ажилгүй байгаа иргэн, зэрэг хүн амын зорилтот бүлэгт чиглэсэн хөтөлбөрүүд хэрэгжих болсон. Хөтөлбөрийн арга хэмжээг өөрчлөхөд уян хатан байх нөхцөл бүрдсэн байна. ХЭД хөтөлбөрийг **өндөр ач холбогдолтой** гэж үнэлэв. ХЭД хөтөлбөрийн хамрах хүрээ хэт хязгаарлагдмал, хөтөлбөрийн хүрээнд олон арга хэмжээ төлөвлөдөг боловч ихэнх нь бага төсөвтэй, цөөн арга хэмжээ нь өндөр төсөвтэй. Хөтөлбөрт хамрагдсан иргэдээс ажлын байртай болсон иргэдийн хувь 20%-д хүрэхгүй байна. Иймд хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн **хангалтгүй эрчимжүүлэх шаардлагатай** гэж дүгнэв. ХЭД хөтөлбөрт зарцуулж буй хөрөнгө үр ашигтай байсан. Төрөөс үзүүлж байгаа хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөтөлбөрт бага зардлаар аль болох олон хүнийг хамруулахыг зорьсон байна. Өнгөрсөн 9 жилд 1.1 сая хүнд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлж, 1 хүнд 8.3 мянган төгрөг зарцуулсан бол ХЭД хөтөлбөрт 480 мянган хүнийг хамруулж, 1 хүнд 546 мянган төгрөг зарцуулсан байна. ХЭД хөтөлбөр, үйлчилгээг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгийг **санхүүжилтийн үр ашигтай байсан** гэж үнэлэв. ХЭД хөтөлбөрт хамруулахаар төлөвлөсөн хүний тоонд хүрч ажиллаагүй, гүйцэтгэл хангалтгүй байсан. Хөтөлбөр, арга хэмжээнд хамруулах хүний тооны квотыг тогтоохдоо орон нутгийн эрэлт хэрэгцээнд үндэслэдэггүй. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, ХЭД хөтөлбөрт чанар, үр дүнгийн хяналт тавьдаггүй байна. Иймд ХЭД хөтөлбөрийн **төлөвлөлтийн хэрэгжилт хангалтгүй** гэж үнэлэв. Хөтөлбөрийн дизайныг өөрчилж, тухайн орон нутгийн онцлогт нийцсэн арга хэмжээг хэрэгжүүлдэг байх уян хатан нөхцөлийг бий болгох шаардлагатай байна.

ХЭД хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой дараах асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай гэсэн дүгнэлт, саналтай байна. Үүнд:

1. ХЭД үйлчилгээ, хөтөлбөрийн хэрэгжилтийн чанар, үр дүнд үнэлгээ тогтмол хийдэггүй. ХЭД хөтөлбөрийн хамрах хүрээ, зорилтот бүлгийг тодорхойлохдоо нарийвчилсан судалгаа, тооцоонд үндэслэдэггүй. Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл, онцлогийг төдийлөн харгалзахгүйгээр ХЭД хөтөлбөрийг улсын хэмжээнд хэрэгжүүлдэг. Хөтөлбөр зарим аймагт амжилттай хэрэгждэг ч зарим аймагт хэрэгжүүлэхэд төвөгтэй байдаг байна. ХЭД хөтөлбөр нь “Халамжаас-Хөдөлмөрт” бодлогын зорилтыг хэрэгжүүлэх зорилтот бүлэгт чиглээгүй байна. Иймд ХЭД хөтөлбөрийн дизайныг сайжруулж, үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.
2. Ажилгүй иргэд, ялангуяа гэртээ хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан асардаг эмэгтэйчүүдэд ХЭД хөтөлбөр, арга хэмжээний талаарх мэдээллийн хүртээмж муу байгаад анхаарч, мэдээллийг хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдийн хөдөлмөрлөх сэтгэлгээг өдөөх нийгмийн маркетингийг өрнүүлэх саналтай байна.
3. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, ХЭД хөтөлбөрт төсөвлөсөн хөрөнгийн зарцуулалт 50-95%-ийн гүйцэтгэлтэй байгаа нь ХЭД хөтөлбөр, арга хэмжээг оновчтой төлөвлөх, хөтөлбөрт оролцогчдын эрэлт, хэрэгцээнд үндэслэх, хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, үр дүнг тооцох үзүүлэлтийг хэмжигдэхүйц болгох, хяналт, тайлагналтын системийг боловсронгуй болгох шаардлагатайг илтгэж байна.
4. ХЭД хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлангийн мэдээллээс арга хэмжээнүүд нь хөдөлмөрийн зах зээл дэх жендэрийн ялгааг бууруулахад чиглэж байгаа эсэхийг дүгнэх боломжгүй байна. Цаашид эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хөдөлмөрийн зах зээл дэх оролцоог нэмэгдүүлэхийн тулд тэдний хэрэгцээнд нийцсэн арга хэмжээг зохион байгуулах саналтай байна.
5. Орон нутгийн ХХҮГ/Х-үүд өөрсдийн онцлогт нийцсэн, амжилттай хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн үр дүнг үнэлж, дараагийн төлөвлөлтөд тусгуулах санаачилгыг идэвхтэй гаргах, ХХҮЕГ-аас хөтөлбөр, арга хэмжээг дүүрэг, орон нутгийн онцлогт тохируулан уян хатан төлөвлөж, шаардлагатай өөрчлөлтийг тухай бүр оруулж ажиллах саналтай байна.
6. ХЭД хөтөлбөр, арга хэмжээний төсвийг батлахдаа хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлыг төсөвтөө тусгах шаардлагатай байна.
7. ХЭД хөтөлбөр ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад тодорхой хэмжээнд нөлөөлж байна. Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааг **иргэн төвтэй** хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд шилжүүлэх саналтай байна.
8. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэхдээ **нэг иргэнд нэг бүртгэл** буюу регистрийн дугаараар түүх үүсгэн бүртгэлжүүлэх саналтай байна.
9. ХЭҮЗ нь жил бүр ХЭД 5-7 хөтөлбөр, 18-33 арга хэмжээ баталдаг боловч төсвийн ихэнх нь **санхүүгийн дэмжлэг, нийтийг хамарсан ажил, сургалт** гэсэн 3 арга хэмжээнд л зарцуулагддаг. Сүүлийн 5 жилийн дунджаас харахад, ХЭД хөтөлбөрүүдийн нийт төсвийн 64-77% нь зөвхөн санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд, төсвийн 14.5-27% нь нийтийг хамарсан ажилд, 3-7.5% нь сургалтын арга хэмжээнд зарцуулагдсан. Тиймээс энэ 3 арга хэмжээг хөтөлбөрт оруулалгүй байнгын арга хэмжээ болгож төлөвлөж, хэрэгжүүлэх нь зүйтэй гэж дүгнэж байна. Ялангуяа санхүүгийн дэмжлэгийн арга хэмжээг мэргэжлийн бусад байгууллагаар гүйцэтгүүлэх саналтай байна.
10. ХЭД хөтөлбөрт хамрагдсан иргэдээс ажлын байртай болсон иргэдийн эзлэх хувь 20%-д хүрэхгүй байна. ААН, ажил олгогчийг дэмжих арга хэмжээг нэмэгдүүлэх, шинээр боловсруулах ялангуяа тогтвортой, зохистой хөдөлмөр эрхлэлтийг бий болгоход чиглэсэн

арга хэмжээний эрэлт хэрэгцээ өндөр байна.

11. Албан бус хөдөлмөр эрхлэлтийг бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.
12. ХЭД сангийн төсвийг УИХ-аас баталсны дараа ХЭҮЗ нь оны дараа хуралдаж, төсөв зарцуулах хөтөлбөр, арга хэмжээ, хуваарийг баталдаг учраас ХХҮГ\Х-үүд санхүүжилтээ авч чадахгүйд хүрч, үйл ажиллагаа нь 4 дүгээр сарыг хүртэл зогсонги байдалтай байдаг. Гэтэл хөдөлмөрийн зах зээл дэх ажиллах хүчний эрэлтийн 70 гаруй хувь жилийн эхний хагаст бий болдог байна. Иймд ХЭҮЗ-ийг оны өмнө буюу 11 дүгээр сарын 15-наас 12 дугаар сарын 25-ны өдрийн хооронд хуралдаж дараа онд хэрэгжүүлэх ХЭД хөтөлбөр, төсвийн хуваарийг батлах цагалбарыг холбогдох хууль тогтоомжид оруулах саналтай байна.
13. ХЭД хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцдог хувийн хэвшлийн байгууллагуудын үйл ажиллагаанд тавих чанарын хяналтыг сайжруулах, хамтын ажиллагааг хөгжүүлэх, тэдний чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хэрэгжилттэй холбоотой дараах асуудлууд байна гэж дүгнэж байна. Үүнд:

1. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ тасралтгүй явагдах ёстой боловч ХЭДС-аас олгох санхүүжилтийн хуваариас шалтгаалан 3 дугаар сараас эхлэн идэвхэждэг.
2. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд мөрдөж байгаа үнэ тарифыг зах зээлийн жишиг үнэд ойртуулах, ижил үйлчилгээнд ижил зардал олгодог болох саналтай байна.
3. Аймаг, нийслэл, дүүргийн ХХҮГ\Х-үүд нь иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгөх, АМЧБ олгох, ажилд зуучлах зэрэг нийтлэг үйлчилгээг нэр төдий хэрэгжүүлж, ХЭД хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээний төсөл, хөтөлбөр шалгаруулахад ихэнх цагаа зарцуулдаг учраас ажилгүйдлийг бууруулах зорилтоо хангаж чадахгүй байна. Иймд ХЭД нийтлэг үйлчилгээний чанар, стандартыг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх, санхүүжилтийг өсгөх саналтай байна.
4. ХХҮГ\Х-үүдийн үйлчилгээний танхим, орох гарах гарцыг ХБИ, ахмад настанд хүртээмжтэй байхаар засаж тохижуулах шаардлагатай байна.
5. Нийтлэг үйлчилгээнд төсөвлөсөн хөрөнгийн зарцуулалтын гүйцэтгэл нь сүүлийн 5 жилд 3.2-90.8% байгаа нь төлөвлөлтийг оновчтой болгох шаардлагатайг харуулж байна.
6. Нийтлэг үйлчилгээнд сүүлийн 9 жилийн хугацаанд 1,107,186 иргэнийг хамруулсан. 2017-2021 онд нийт 189,381 хүнийг ажилд зуучилсан байна. Үүний 90 гаруй хувь нь буюу жилд 30 гаруй мянган хүнийг ХХҮГ\Х-үүд ажилд зуучилсан байна. Энэ үзүүлэлт хэр бодит болохыг нягталж, аймаг, дүүргийн ХХҮГ\Х-ийн ажилд зуучлах үйлчилгээний квотыг бодитоор тогтоох шаардлагатай юм.
7. Ажил хайгчаасаа олон хүнийг ажлын байранд зуучилсан гэсэн статистик үзүүлэлт гарч байгаа нь бодит байдалтай нийцэхгүй байна. Иймд бүртгэл мэдээллийн систем, түүний хяналтыг сайжруулах шаардлагатай байна.
8. Хөдөлмөр зуучлалын хувийн байгууллагад олгох санхүүжилтийг 2-3 сараар хоцроодог байна. Эдгээр байгууллагад ажил олгогчтой харилцаа холбоо тогтоох, тэдэнд сургалт явуулах зардал болон ажил хайгчийн хөдөлмөр эрхлэлтийн ур чадварын үнэлгээ хийх зардал зэргийг нэмж олгон үйл ажиллагааг нь өргөжүүлэн идэвхжүүлэх шаардлагатай байна.
9. Хөдөлмөрийн хувийн биржүүдийн үйл ажиллагаанд тавих чанарын хяналтыг сайжруулах саналтай байна.

6

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Веб сайт:

1. www.legalinfo.mn
2. www.1212.mn
3. www.rilsp.gov.mn
4. www.hudulmur-halamj.gov.mn

Хууль, тогтоомж, бодлого, журам:

1. “Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой Хөдөлмөрийн тухай” хууль, (1999, 2021 он)
2. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” хууль, (2011 он)
3. “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” (Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол)
4. “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”, (МУ-ын ЗГ-ын 2016 оны 320 дугаар тогтоол)
5. “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, (УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол)
6. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний нэгжид ногдох зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай”, (Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/96 тоот тушаал)
7. “Хөдөлмөрийн хувийн биржийг бүртгэж, санхүүжилт (тарифаар тооцож) олгох журам”, (Хөдөлмөрийн сайдын 2014 оны А/123 тоот тушаал)
8. ХЭҮЗ, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг батлах тухай” тогтоол, (2012-2022 он)
9. Хөдөлмөрийн салбарын ажилтны гарын авлага (2013 он)

Судалгаа, тайлан:

1. ҮСХ, “Ажиллах хүчний судалгаа”, (2021 оны IV улирал)
2. Development Assistance Committee, Principles for Evaluation of Development Assistance, Paris 1991
3. The DAC Principles for the Evaluation of Development Assistance, OECD (1991), Glossary of Terms Used in Evaluation, in ‘Methods and Procedures in Aid Evaluation’, OECD (1986), and the Glossary of Evaluation and Results Based Management (RBM) Terms, OECD (2000)
4. Селин Ферре, “Монгол улсын хөдөлмөрийн зах зээлийн үйлчилгээ, хөтөлбөр”, хөдөлмөр эрхлэлтийн төрийн үйлчилгээний үнэлгээний тайлан, (2020 он)
5. Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого 2016-2020 оны хэрэгжилтийн үнэлгээ, судалгааны тайлан (2021) SICA

ХАВСРАЛТ 1: ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙН ТӨРЛҮҮД

2012 оны 12-р сарын 12-нд баталсан	2014 оны 1-р сарын 13-нд баталсан	2015 оны 2-р сарын 12-нд баталсан	2015 оны 12-р сарын 16-нд баталсан	2017 оны 1-р сарын 27-нд баталсан	2019 оны 1-р сарын 14-нд баталсан	2021 оны 2-р сарын 9-нд баталсан
1. Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр	1. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	1. ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧ, НӨХӨРЛӨЛ, ХОРШОО БАЙГУУЛАХ ИРГЭНИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР	1. АЖ АХУЙ ЭРХЛЭХ, БИЧИЛ БИЗНЕСНИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР	1. Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн үр чадвар олгох хөтөлбөр	1. Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн үр чадвар олгох хөтөлбөр	1. Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр
2. Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах хөтөлбөр	2. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	2. Хөдөлмөр эрхлэлтийн үр чадвар олгох, ажлын байр хадгалах хөтөлбөр	2. Хөдөлмөр эрхлэлтийн үр чадвар олгох, ажлын байрыг дэмжих хөтөлбөр	2. Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	2. Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	2. ЦАР ТАХЛЫН ҮЕД АЖ АХУЙ ЭРХЛЭГЧДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ СЭРГЭЭХ ХӨТӨЛБӨР
3. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	3. Оюутны хөдөлмөр эрхлэлт ба цагийн ажил хөтөлбөр	3. Залуучууд мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	3. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	3. Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	3. Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	3. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
4. Хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр	4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	4. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
5. Ажил олгогчийг дэмжих хөтөлбөр	5. Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөр	4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	5. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	5. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	5. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	6. Эзэнтэй монгол хөтөлбөр	5. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	6. Нийтийг хамарсан ажил зохион байгуулах хөтөлбөр	6. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	6. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	6. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
7. 40-өөс дээш болон ахмад насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	7. Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр	7. Хөдөлмөр эрхлэлтийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	7. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээг дэмжих хөтөлбөр	8. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний төсөл		
8. Эзэнтэй монгол хөтөлбөр	8. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ төсөл	9. Аж ахуй эрхлэлтийг хөгжүүлэх хөтөлбөр	10. 40-өөс дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр			

ХАВСРАЛТ 2: АСУУЛГЫН АНКЕТ 1

/Төрийн байгууллагын ажилтан бөглөнө/

Хөдөлмөр эрхлэлтийн бодлого үйл ажиллагаанд таны санааг тусгах, хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор энэхүү санал асуулгыг авч байгаа тул та идэвхтэй оролцоно уу.

1. Таны ажилладаг байгууллага

а/ ХНХЯ б/ ХХҮЕГ в/НХЭГ г/аймгийн ХХҮГ д/дүүргийн ХХҮХ
е/ ОУ-ын төсөл ё/ Бусад _____

2. Танай байгууллагын байршил

а/ Төвийн бүс б/ Баруун бүс в/ Хангайн г/ Зүүн д/ Улаанбаатар

3. Таны ажлын байрны чиг үүрэгт дараах асуудлын аль нь хамаардаг вэ?

а/ Бодлого төлөвлөх
б/ Бодлогыг хэрэгжүүлэх арга зүйг боловсруулах
в/ Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааг дэмжих
г/ Зөвлөх
г/ ХЭ нийтлэг үйлчилгээг үзүүлэх
д/ ХЭД арга хэмжээг хэрэгжүүлэх
е/ Бусад _____

4. Та хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцан хэдэн жил ажиллаж байна вэ?

а/ 1 жил хүртэл б/1,1-3 жил в/3,1-5 жил, г/ 5,1-10 жил д/10-аас дээш

5. Таныг ажлаа хийхэд ямар бэрхшээл тулгардаг вэ?

а/ Арга зүй, удирдамж тодорхой биш
б/ Мэдээлэл дутмаг
в/ Ажлын ачаалал их
г/ Урам, мотиваци байхгүй
д/ Зорилтот бүлгийн гишүүдтэй харилцахад хүндрэлтэй
е/ АБТ заагдаагүй ажлууд хийгддэг
ё/ Бусад _____

6. Та хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ арга хэмжээг сайжруулах талаар санал санаачилга гаргаж байсан уу?

А.Тийм Б. Үгүй

7. Тийм бол ямар санал гаргаж байсан бэ?

8. Одоогийн байдлаар хөтөлбөрүүдийн үр дүнг тооцдог эсэх

А.Тийм Б. Үгүй

9. Хэрвээ тийм бол ямар хугацаанд хэрхэн тооцож байна вэ?

**10. 2021 онд хэрэгжсэн хөтөлбөрүүдэд үнэлгээ өгнө үү.
/Сайн-5 муу-1 хүртэл оноо өгнө үү/**

Хөтөлбөрийн нэр	1	2	3	4	5
Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр					
Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр					
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр					
Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр					
Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр					

11. Дараахаас аль нь хамгийн үр дүнтэй хэрэгжсэн бэ?

- а/ АМЧБО зөвлөгөө
- б/ Ажилд зуучлах
- в/ Сургалт
- г/ Санхүүгийн дэмжлэг
- д/ Нийтийг хамарсан ажил зохион байгуулах
- е/ Гарааны бизнесийг дэмжих
- ё/ Бусад _____

12. Ямар шалтгаанаас арга хэмжээнүүд хэрэгжихгүй байсан бэ?

- а/ Хөтөлбөрийн арга хэмжээ оновчгүй
- б/ Зохион байгуулах газар, хэлтсийг зөв тодорхойлоогүй
- в/ Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдамж батлагдаагүй
- г/ Арга хэмжээнд төсөв хуваарилаагүй
- д/ Хэрэгжүүлэх хүний нөөц дутмаг

е/ Орон нутгийн онцлогт тохироогүй

ё/ Бусад _____

13. Танай бодлоор цаашид ямар хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна вэ?

14. Аль зорилтот бүлэгт чиглэсэн хөтөлбөр шаардлагатай байна вэ?

Нэн тэргүүнд шаардлагатай 3 зорилтот бүлгийг дугуйлна уу?

1. Ажилгүй иргэн
2. Ажилгүйдлийн тэтгэмж авах эрх үүссэн иргэн
3. 6 сараас дээш хугацаагаар ажил олж чадахгүй байгаа иргэн
4. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай гишүүн
5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
6. Ажил олгогч байгууллага
7. Бичил бизнес эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, , нөхөрлөл, хоршоо
8. 16-34 насны бизнес эрхлэгч залуучууд
9. Орон нутгийн иргэдийн бүлэг
10. Малчин
11. Бусад _____

15. Хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд юу шаардлагатай вэ?

16. Цаашид нийтлэг үйлчилгээ, арга хэмжээг яаж хэрэгжүүлбэл үр ашигтай болно гэж үзэж байна вэ?

17. Хөдөлмөр эрхлэлтийн бодлогод таны санал болгох зүйл

Танд баярлалаа

ХАВСРАЛТ 3: АСУУЛГЫН АНКЕТ 2

/ХЭД хөтөлбөрийг гэрээлэн гүйцэтгэгч байгууллага/

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг сайжруулахад оролцогч талуудын үзэл бодлыг дэмжиж, сайжруулахад оролцогч талуудын үзэл бодлыг тусгах зорилготой судалгаанд хамрагдаж байгаа танд талархал илэрхийлье.

Олон хариултууд сонгож болно.

1. Танай байгууллагын үйл ажиллагааны чиглэл

- а/ АМЧБО зөвлөгөө б/ Сургалт в/ Төсөл боловсруулах
г/ Ажилд зуучлал г/ Бусад

2. Танай байгууллагын газарзүйн газарзүйн байршил

- а/ Төвийн бүс б/ Баруун бүс в/ Хангайн г/ Зүүн д/ Улаанбаатар

3. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөтөлбөрийг хэдэн жил ажиллаж байгаа вэ?

- а/ 1 жил хүртэл б/1.1-3 жил в/3.1-5 жил, г/ 5.1-10 жил д/10-аас дээш

4. Дараах байгууллагын алинтай нь гэрээ байгуулж ажилласан бэ?

- а/ ХХҮЕГ б/НХЭГ в/аймгийн ХХҮГ, г/дүүргийн ХХҮХ г/ Үгүй

5. АМЧБО зөвлөгөө, ажилд зуучлахад тулгарч байгаа гол бэрхшээл юу вэ?

- а/ Бичиг баримт бүрдүүлэхэд хүндрэлтэй
б/ Төрөөс санхүүжилтийг цаг хугацаанд нь олгодоггүй
в/ Санхүүжилтийн хэмжээ үйл ажиллагаандаа хүрэлцдэггүй
г/ Ажил олгогчийн шаардлага хангасан ажил хайгч олддоггүй
д/ Ажил хайгчийн хүссэн ажлын байр олддоггүй
е/ Бусад _____

6. Дараах хөтөлбөр, арга хэмжээнээс алийг нь хэрэгжүүлэхэд оролцсон бэ?

а/ Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр

1. Хөдөлмөрт бэлтгэх
2. Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах
3. Нийгмийн хариуцлагатай ажил олгогчийг шалгаруулах

б/ Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр

4. Иргэн, ААН-д санхүүгийн дэмжлэг олгох
5. Малчдын малжуулах
6. Борлуулалтын дэмжлэг үзүүлэх

7. Ажил олгогчийг дэмжих
8. Нийтийг хамарсан ажил зохион байгуулах

в/ Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр

9. Залуучуудад хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлэх
10. Залуучуудад ажлын дадал, туршлага эзэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх
11. Шилдэг “Старт-Ап” залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох
12. Оюутан залуучуудыг цагийн ажилд зуучлах

г/ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр

13. ХБИ-г хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллахад дэмжлэг үзүүлэх
14. Санхүүгийн дэмжлэг олгох
15. ХБИ-д ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх
16. Ажлын байрны түрээсийн төлбөрт дэмжлэг үзүүлэх
17. Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах

д/ Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр

18. Ахмад настны зөвлөх үйлчилгээг зохион байгуулах
19. Ахмадын ТББ-уудаар зөвлөх үйлчилгээг зохион байгуулах
20. Эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг олгох

7. ХЭД хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд гол хүндрэл бэрхшээл нь юу байв?

- а/ Сургалтад хамрагдах хүн олддоггүй
- б/ Санхүүжилтийн хэмжээ үйл ажиллагаандаа хүрэлцдэггүй
- в/Төрийн байгууллагын хүнд суртал их
- г/ Төлбөрөө цаг хугацаандаа шилжүүлдэггүй
- д/ Хөтөлбөр хэрэгжих цаг хугацаа тохиромжгүй
- е/ Бусад _____

8. Сургалтыг аль аль саруудад зохион байгуулах нь тохиромжтой вэ?

Сарууд 1 2 3 4 5 6 7 8 9 10 11 12

9. Оролцсон хөтөлбөрийнхөө давуу талыг нэрлэнэ үү.

10. Оролцсон хөтөлбөрийнхөө сул талыг нэрлэнэ үү

11. 2021 онд хэрэгжсэн хөтөлбөрүүдэд үнэлгээ өгнө үү.

/Сайн-5 муу-1 хүртэл оноо өгнө үү/

Хөтөлбөрийн нэр	1	2	3	4	5
Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр					
Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр					
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр					
Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр					
Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр					

12. Аль зорилтот бүлэгт чиглэсэн хөтөлбөр шаардлагатай байна вэ?

Нэн тэргүүнд шаардлагатай 3 зорилтот бүлгийг дугуйлна уу?

1. Ажилгүй иргэн
2. Ажилгүйдлийн тэтгэмж авах эрх үүссэн иргэн
3. 6 сараас дээш хугацаагаар ажил олж чадахгүй байгаа иргэн
4. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай гишүүн
5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
6. Ажил олгогч байгууллага
7. Бичил бизнес эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, , нөхөрлөл, хоршоо
8. 16-34 насны бизнес эрхлэгч залуучууд
9. Орон нутгийн иргэдийн бүлэг
10. Малчин
11. Бусад _____

13. Таны бодлоор хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг сайжруулахын тулд юу хийх вэ?

14. Таны бодлоор хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд юу хийх вэ?

15. Хөдөлмөр эрхлэлтийн бодлогод таны санал болгох зүйл

Танд баярлалаа.

